



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧҮҮЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

## НЭГДСЭН ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-45</i>
<hr/>	
<i>1.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайдын мэдээлэл /Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар/</i>	<i>6-44</i>
<i>2.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай</i>	<i>44-45</i>

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 21-ний өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Батиугар, Х.Булгантуяа, Д.Сарангэрэл;

Тасалсан: А.Адъяасүрэн, Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Ц.Туваан;

Хоцорсон: С.Батболд-1 цаг 30 минут, Ж.Бат-Эрдэнэ-1 цаг 05 минут, С.Ганбаатар-54 минут, Г.Дамдинням-14 минут, Б.Жавхлан-14 минут, Ж.Мөнхбат-16 минут, Ц.Мөнх-Оргил-22 минут, Х.Нямбаатар-38 минут, Ц.Сэргэлэн-2 цаг 49 минут, Н.Учрал-25 минут, Н.Энхболд-22 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, О.Цогтгэрэл, Д.Өнөрболор, Н.Алтанхуяг нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, О.Цогтгэрэл, Д.Өнөрболор, Н.Алтанхуяг нар үг хэлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тайлбар хийв.

**Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар “Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар”/**

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулхар, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.10-г заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар /цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар “Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар”/ мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Г.Дамдинням, Ш.Адъяа, С.Чинзориг, Б.Пүрэвдорж, Х.Баделхан, С.Одонтуяа, Т.Энхтүвшин, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар “Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар” мэдээлэл хийлээ.

*Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Хоёр.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, ахлах референт Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханыг томилох талаар танилцуулав.

Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа, Н.Учрал, Б.Жаргалмаа, Б.Баярсайхан нар үг хэлэв.

*Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 49 минут үргэлжилж, 12 цаг 54 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.*

### ***Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг мэдээлэх***

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг:

1. Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2022.10.12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

2. Засгийн газраас 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Х.Ганхуяг нараас 2022.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээ татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./14:03/

### ***Хоёр. Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа***

Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, мөн газрын шинжээч Б.Мөнхбилгүүн нар оролцов.

Ёслолын ажиллагаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, мөн газрын шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

Танхимын зүүн хойд дэлгэцэн дээр “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” гэсэн Засгийн газрын гишүүний тангарагийн үг гарч байв.

“Их хуралдай” танхимын голд Төрийн далбаа, Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт, түүний урд Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэсэн индрийг байрлуулж, Төрийн сүлдний зүүн, баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т заасны дагуу шинээр томилогдож буй Засгийн газрын гишүүний нэрийг дуудав.*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан.

Нэр дуудагдсан Засгийн газрын гишүүн суудлаасаа босож индрээс “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн тангараг өргөв.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүн Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын 1 гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг чуулганы танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүнд баяр хүргэж, үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүдэд хандан мэхийн ёслол.

*Тангараг өргөх ёслолын ажиллагаа 14 цаг 08 минутад өндөрлөв.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн “Оюуны ундраа” сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн урилгаар Баянзүрх дүүргийн 36 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын багуудын иргэдийн Нийтийн Хурлын дарга нар, Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг нарын урилгаар Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн багш, ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 76 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 77.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 09 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022  
ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ  
ЧУУЛГАНЫ  
10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР  
/БААСАН ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Өглөөний амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байгаа тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10-дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Цаг үеийн шинжтэй, тулгамдсан асуудлаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно. Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9-ийн тавд заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг асуудал нэмэх, дараалал өөрчлөх асуудлыг хойшлуулах горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа, Одонгийн Цогтгэрэл, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Норовын Алтанхуяг нараас албан бичгүүд ирүүлсэн байна.

Бичгүүдийг бүгдийг нь уншиж танилцуулахаар агуулга нэг л юм байна. Үндэслэлүүдээ ихэнхийг нь бичсэн, зарим нь бичээгүй байна шүү. Үндэслэл бүхий санал ирүүлэх ёстой гэж байгаа юм. Ингээд дарааллын дагуу эрхэм гишүүн Ширнэнбаньдын Адьшаа үг хэлнэ.

**Ш.Адьшаа:** Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас энэ төсвийн хуультай уялдуулж олон хуулийн төслийг өөрчлөх ийм санал оруулж ирсэн байгаа. Энэ олон хуулийн төслийг өөрчлөх энэ санал дотор өнөөдөр юу нүүгдээд байгаа гэдгийг би бүр гайхаж байна. Энэ дээр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөх оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн байна. Засгийн газрын салбар хариуцсан сайдаас нь санал авахгүйгээр энэ хуулийн төслийг оруулж иржээ.

Энэ хуулийн төслийн гол үзэл баримтлал нь нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээ байгуулж, хандив тусламж авах тухай зохицуулалтыг оруулж ирсэн байна. Дээр нь ажиллах хүчний тухай асуудлыг нь хөндөж ярьжээ. Энэ одоо юу вэ? Гишүүдээ жаахан чимээгүй байж байгаарай. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаагийн 2-т зааснаар газрын доорх баялаг төр, нийтийн өмч байна гэж байгаа юм. Бид өнөөдөр Ашигт малтмалын хуулийн дагуу газар нутгийнхаа ихэнхийг лиценз хэлбэрээр гадна дотнынхон өгчихсөн байна. Үүнээс үүдэж гарсан нийгэмд бухимдал өнөөдөр ямар байгаа билээ?

Гэтэл өнөөдөр энэ Төсвийн тухай хуулийг далимдуулж ийм зүйл оруулж ирсэн нь хардлага төрүүлж байна. Нийгэмд хардлага төрүүлж байна. Өнөөдөр хэдхэн тооны хүнд ажил олгох, нутгийн захиргааны байгууллагад хандив тусламжийг өнөөдөр хуулиар олгосноор тэр лицензээс эзэмшигчид өнөөдөр нутгийн иргэдэд хэдэн төгрөгийн хандив өгөөд тэр хандивын сургууль, эмнэлэг гэдэг нэрийдлийн дор орон нутгийн хэдхэн дарга нар хувааж авдаг энэ тогтолцоог хуулиар батлгаажуулж байгаад харамсаж байна. Засгийн газар энэ хуулиа татаж ав аа. Ингэж болохгүй ээ.

Дээр нь энд урьдчилан төлөвлөсөн юм шиг Ховд аймгийн иргэдийн Хурал өнөөдөр ээлжит бус хуралдаан зарлаж,



Их нууруудын хотгор гэдэг Монгол Улсын цэвэр усны нөөцийн 70 хувь байдаг энэ газарт өнөөдөр Ашигт малтмалын газрын тосны хайгуул хийлгэх асуудлыг авч хэлэлцэж байна. Энэ одоо юу вэ? Талх Ганхуяг гээд нэг нөхөр очиж өчигдөр өвс тэжээл өгсөн. Дээр нь тэр Ганхуягийн дүү Гантулга гэдэг Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ашиглалтын өмнөх захиргааны дарга, энэ нөхдүүд өнөөдөр энэ баруун бүсийн, түүний дотор Хар ус нуурын ай сав газрын гадаад дотоодынхонтой нийлж, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаар далайлгаж ийм хууль бус үйл ажиллагаа явуулахыг бид зөвшөөрөхгүй ээ. Засгийн газар ийм увайгүй юмаа боль оо. Гуя дагуулсан хүзүү гэгчээр энэ Төсвийн хуулиар далимдуулж ийм хулгай луйвар яаж хийх гээд байгаа юм?

Газрын тухай баялаг чинь өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаагийн 2-т зааснаар нийт ард түмний өмч, энэнээс монголчууд хувь хүртэнэ гэж байгаа шүү дээ, тэгш хувь хүртэнэ. Гэтэл өнөөдөр хандив тусламж, ажлын байр гэдэг нэрийдлээр хуульчилчихад тэнд ямар юм хийх гээд байна аа? Энэ зүйлээ Засгийн газар татаж ав аа. Энийг зөвшөөрч болохгүй ээ. Та нар өнөөдөр ард түмний төлөөлөл. Энэ Их Хурлын гишүүд ээ, энэ дээр энэ хуулийн төслийг та нар хэлэлцвэл маш том эрсдэл, үр дагавар үүснэ шүү. Энд ямар нэгэн популизм хийх гээгүй, бодит байдлыг ярьж байна. Энэний чинь үр дагавар нь өнөөдөр Ховд аймагт нүүрлэж эхэллээ.

Өнөөдөр Ховд аймагт аймгийн иргэдийн Хурал ээлжит бус хуралдаан зарлаж энэ асуудлыг авч хэлэлцэх гэж байна. Ийм байдлаар цаашидаа бид нар улс орныхоо байгалийн баялгийг, ард түмнийхээ баялгийг ийм хуулийг хулгайгаар далимдуулж ингэж баталгаажуулах юм уу? Энэнд та нар ямар байр суурьтай байна, энэ дээр онцгой анхаараарай. Засгийн газар өнөөдөр Сангийн яам, салбарын сайдаас нь зөвшөөрөл аваагүй гэж Ганбаатар

сайд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дээр хэлж байна лээ шүү дээ. Ингэж болохгүй ээ. Энэ асуудлыг хойшлуулъя. Энэ асуудлаа татаж авахыг би Засгийн газраас шаардаж байна. Хэрвээ энэ асуудлаа татаж авахгүй, ийм байдлаар байгалийн баялгийг, ард түмний баялгийг энэ эдийн засгийн хүнд байдлыг далимдуулж.

**Г.Занданшатар:** Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд ийм хууль байхгүй байгаа. Энэ асуудлыг хэлэлцэх эсэх үед нь ярьж, буцаах, дэмжихгүй байх саналуудаа хэлж ярьж. Дэмжих, дэмжихгүй санал хэлдэг шүү дээ, хэлэлцэх эсэх дээр. Миний ойлгосноор төсөв дагасан хуулиудыг чинь өнгөрсөн 7 хоногт хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн юм биш үү? Эдийн засгийн байнгын хороон дээр тэгээд сайн яриарай. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Өглөөний мэнд хүргэе. Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд 14 цагаас байсан Ерөнхий сайдын мэдээллийн тухай л ярих гээд байна л даа. Сүүлийн хуралдааны дэгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдын мэдээллийг 14 хоногийн өмнөөс мэдэгддэг, 7 хоногийн өмнөөс Д-парламентад байршуулдаг, санал ирдэг, сөрөг хүчнээс 25 минутын дотор мэтгэлцээний журмаар асуудаг гээд ингээд өөрчлөлтүүд орсон. Гэтэл одоо яг процесс яваад 7 хоног асуулт, санал асуулт, иргэдийн асуулт нэгтгэгдээд ирж байхад ингээд шууд өмнөх өдөр нь нөгөө мэдээлэл байхгүй. Тэгэхээр энэ яг дэгийн хуулийн хэдийн хэдээр яг ямар зохицуулалтаар энэ зүйл заалт ингэж байхгүй болж болж байгаа юм бэ?

Хоёрдугаарт нь, хоёр жилийн хугацаанд Ерөнхий сайдын мэдээлэл гээд хариуцлагатай, тэр тусмаа сөрөг хүчин асуудаг ийм бас нэг хуулийн зүйл заалт, ард иргэдийн үндсэндээ мэдэх эрхэд боломж олгосон ийм давуу талтай зүйл заалт байдаг. Энэ хугацаанд Ерөнхий сайд хоёр жилийн хугацаанд ганц ч удаа

мэдээлэл хийсэнгүй. Тэгэхээр яг онцгой шаардлагатай бол мэдээлэл хийхгүй байж мэдээж болох байх. Гэтэл хоёр жилийн хугацаанд хоёр жилжин онцгой шаардлагатай байна, онцгой нөхцөл байдалд байна гэж бас байх уу? Энэ өөрөө бас Улсын Их Хурлын өөрийнх нь асуудал байх аа. Улсын Их Хурлын дарга энэн дээр бас анхаараач. Ерөнхий сайд ч гэсэн энэн дээр олон нийтэд бас мэдээлэл хийхэд өөрт нь магадгүй илүү тийм бодлогоо таниулахад давуу талтай ч байсан энэ үүрэг функцыг ерөөсөө хэнд ч хэрэггүй нэг ийм үйл явц болгож хувиргаж байна.

Өнгөрсөн хоёр 7 хоногийн өмнө болсон нь Ерөнхий сайдын мэдээлэл харьцангуй үр дүнтэй, иргэдээс ирсэн маш олон асуулт асуултад иргэд гишүүдээр дамжуулж хариулт аваад ийм процесс болж байсан. Тэгээд л өнөөдөр өмнөх өдөр нь цуцаллаа гэдэг. Дэгийн тухай хууль үзэхэд энэ дээр яг цуцалж болох тухай зүйл заалт бид нар олж хараагүй. Тэгэхээр Их Хурлын дарга энэн дээр нэг тайлбар өгөөч. Цаашидаа Ерөнхий сайдын мэдээллийг илүү үр дүнтэй, зохион байгуулалттай, тэр хуулийн хүрээнд нь явуулж өгөхийг танаас бас бид нар хүсээж бас ингэж шаардаж байгаа юм.

### **Г.Занданшатар:**

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн

**Д.Өнөрболор:** Эрхэм гишүүддээ өнөөдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр энэ хэлэлцээж байгаа асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурал дээр хэлэлцээж байгаа хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын байр сууриа илэрхийлье гэж бодож байна. Гишүүд бас энэ асуудалд анхаарлаа хандуулахыг хүсье.

Ирэх 7 хоногт Засгийн газраас өргөн барьсан байж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн тухай төслийн анхны хэлэлцүүлгийг хийх асуудал яригдаж байгаа юм байна. Одоогоор өргөн баригдсан хуулийн төсөл нь бол үндсэндээ концессын хүчин

төгөлдөр үйлчилж байсан хуулийг бол засан сайжруулах, энэ хуулийг хэрэгжүүлэх явцад гарсан алдаа дутагдлыг залруулахад л гол анхаарлаа хандуулсан болохоос биш төр, хувийн хэвшлийн түншлэлийн сонгодог концепцыг орхигдуулсан ийм хууль батлагдах эрсдэл өнөөдөр бид нарт үүсээд байна.

Энэ хувилбар явснаар өнөөдөр хувийн хэвшил мөн хөрөнгө оруулалтыг татаж дэмжих нь байтугай шинэ сэргэлтийн бодлогын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин огт бүрдэхгүй ийм нөхцөл байдал бол үүсээд байна. Ер нь бол бид төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг маань өөрөө юу байдаг юм бэ гэдгийг нэг ойлголтод хурч ойлгох нь чухал байгаа юм. Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчныг өнөөдөр бид нар зөвхөн төр, засгийн эрх мэдлийг төвлөрүүлэх, мөн хянан шалгах зөвшөөрөл олгох ч байдаг юм уу, ийм хүнд суртлын хараагаар биш, зөвхөн Монгол Улсын эдийн засгийг зөвхөн төсвийн хараагаар ингээж зохицуулах биш, үндсэндээ энэ хууль бол хууль, эрх зүйн стратегийн түншлэлийн, хувийн хэвшлийн, хөрөнгө оруулалтын гээд олон талаас нь харж бүрдүүлэх ёстой ийм хууль байгаа.

Гэтэл энэ хуулийн төсөл бүхэлдээ төсвийн хөрөнгө оруулалтаар буюу төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх ийм л хараагаар боловсруулагдчихсан байгаад гол асуудал болоод байгаа юм. Тэгээд үндсэндээ энэ өргөн барьсан хуулийг төсвийн хөрөнгөөр хувийн хэвшилээр төсөл, хөтөлбөр гүйцэтгүүлэх тухай гэж нэрлэх нь зүйтэй. Ийм хуулиар бүхэлд нь төр, хувийн хэвшлийн сонгодог зарчмыг алдагдуулж болохгүй ээ. Зах зээл дээрх энэ боломжуудыг нээх биш, харин боомилсон ийм хуулийг бол бид нар зөвшөөрч болохгүй. Тэгэхээр Занданшатар дарга аа, өнөөдөр бид нар энэ парламент анхдугаар хурлаараа гурван гол реформын

нэг болох эдийн засгийн реформыг бид нар хийнэ гэдгээ зарласан. Тэгэхээр энэ концепц ер нь одоо алдагдаж байна. Энэ ер нь концепц ер нь хаачихав аа?

Миний бие бол улс орны эрх ашиг, ирээдүйн хөгжлийн бас дараагийн 20, 30 жилийн асуудал хувь заяаг шийдвэрлэх энэ эхлэл суурийг нь яг тавьж байгаа харцуцлагатай энэ цаг үед бид улс орны ирээдүйг ухраасан, гацаасан ийм хуулийг бол би дэмжихгүй ээ. Тэгээд одоо хүч түрээд явуулах ийм шинж ажиглагдаж байна л даа. Тэгэхээр гишүүд ч бас үүн дээр нухацтай хандахыг би анхааруулж байна, Наранбаатар гишүүн ээ. Та бүгд ч гэсэн бас Монгол Улсын эрх ашиг, ирээдүйг гацаагчид болж хувирна шүү. Тэгэхээр энэ дээр бол анхааралтай хандаач ээ гэж та бүгдээс хүсэж байна.

ОУВС-гаас ч гэсэн 2023 он бол дэлхийн эдийн засгийн өсөлтөө бууруулсан. Бидэнд тохиолдож болох хамгийн муу зүйл бол хараахан болоогүй байна. Ер нь олон улс бол энэ 2023 онд маш их уналт руу орно гэж анхааруулсан байж байгаа. Энэ агуулгаараа ч гэсэн Монгол Улс эдийн засгийн хямрал бодитоор болж байна. Улс орны эдийн засаг агишиж байна. Өнөөдөр хөрөнгө оруулалтын идэвх буурч байна, төсвийн хөрөнгө оруулалт 0 боллоо, өр зээл таазандаа тулж байна. Өнөөдөр валют орж ирдэг цонхнууд бол үндсэндээ хумигдлаа.

Энэ болгон бол тоо баримтаар тодорхой харагдаж байгааг бид мэдэж байна. Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль бол том агуулгаараа энэ үүргээ гүйцэтгэх цаг хугацаа юм. Тэгэхээр энэ эдийн засгаа тэтгэх яг олон асуудлыг шийдвэрлэх энэ хуулийг нийгэм, хувийн хэвшил, Засгийн газрын хүлээлт болодоо маш өндөр байна. Тэгэхээр Сангийн яам харамсалтай нь энэ хуулийн өнөөгийн эрэлт хэрэгцээ, энэ концепц агуулгад бол нэн ялангуяа эдийн засаг хүндэрч байгаа энэ цаг үед төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн оролцоог зах зээлд нэмэгдүүлэх энэ тал

дээр бол үнэхээр ажилласангүй ээ. Энэ хууль бол үнэхээр төр, хувийн хэвшлийн эмзэг байгаа харилцааг шинэ шатанд гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж чадсангүй ээ. Тийм учраас Засгийн газар энэ хуулиа татаж авах талаар би бас албан ёсоор шаардаж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын Оюуны ундраа сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурагчид та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Сурах чиглэлийг эрхэм болговоос хандах зүг өөрөө тогтоно гэж.

Өнөрболор гишүүн ээ, өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд Төр, хувийн өмчийн түншлэлийн хууль байхгүй. Ирэх 7 хоногт ч гэсэн байгаа эсэхийг бид мэдэхгүй байна. Ажлын хэсэг та бүхэн Сангийн яамтайгаа яриад оруулж ирээд тэндээ учраа олоод, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл учраас Засгийн газар тэгээд эдийн засгийн реформын хүрээнд л оруулж ирсэн гэж л. Хэлэлцүүлэг Д-парламент дээр байршсан байгаа. Тэрэн дээр санал зохион байгуулж болно, хэлэлцүүлгүүд одоо хийсэн байх гэж найдаж байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхим хувийн хэвшлийнхээ санал бодлыг сонссон байх гэж найдаж байна. Тэр хүрээндээ сайн хэлэлцэж ярилцаагаарай, хэлэлцүүлгүүдээ сайн хийгээрэй.

Ингээд дараагийн асуудал нь Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Би хэлэлцэх асуудалтай холбогдуулаад, ялангуяа улсын төсвийг хэлэлцэж байгаа энэ үеэр дандаа улсын төсвийг хэлэлцэж

байгаатай холбогдуулаад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн ийм юм орж ирдэг л дээ. Гэхдээ энэ удаа бол бас жаахан буруу л юм хийж байна гэж бодож байна.

Би Адьшаа гишүүний хэлж байгаа саналыг бас дэмжиж үг хэлэх гэж байгаа юм. Ер нь Жавхлан сайд, Засгийн газар, Их Хурал, Ардын намын 62 та нар нэг юм анхаарахгүй бол энийг хуулийн хулгай гэдэг юм л даа. Төсвийн хуулийг хэлэлцэж байхад хажуугаар нь янз бүрийн хууль оруулаад давхар батлуулдаг нэг ийм практик өмнө нь ч бас явж явсан. Одоо энэ хууль дээр би хоёр юм хэлье. Өмнө нь нэг гарсан гурван жишээ та нарт хэлье л дээ. Кэйс хэлье.

Жишээлэх юм бол Монгол Улсын Шадар сайдын тухай асуудлыг төсөв дагадаг хуулиар ярьдаггүй ээ. Шадар сайдтай байж болно, Хөгжлийн асуудал хариуцсан тэр сайд нь шадар сайд байхыг би бол хувьдаа дэмждэг. Тэгэхдээ хулгай хийж, ингэж төсөв ярьж байхад хажуугаар нь оруулж ирж тэр хүний урд талд шадар сайд гэдгийг нэмж болохгүй. Энэ бол Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиар тусгайлан авч хэлэлцээд тусгайлан ярих ёстой. Яагаад ийм хулгай хийгээд байгаа юм бэ? Би ойлгохгүй юм.

Хоёр дахь нь Ашигт малтмалын тухай хуулийн, ялангуяа Ардын намынхан, Ашигт малтмалын хуулийн асуудлаар монголчууд энэ баялагтаа эзэн болох юм уу, эс болох юм уу? Эсвэл та нар тэр амлалтаасаа буцчихсан юм уу гэдгээ ард түмэндээ хэлмээр байна. Одоо энэ Ашигт малтмалын тухай хуульд орж ирж байгаа өөрчлөлт бол Ганбаатар сайд нь өөрөө санал өгөөгүй байхад Төсвийн хуулийг дагуулж хулгай хийж байна. Орон нутагт эрх мэдэл өгөх нэрийдлээр орон нутаг, хээл хахууль, авлигад идэгдэх ийм боломжийг гаргаж өгч байна. Энийг бас хуулийн хулгай гэж хэлнэ.

Гуравдугаар жишээ би хэлье. Үүсмэл орд гэж нэг шинэ юм гаргаж ирсэн юм. Миеэгомбын Энхболд Их Хурлын дарга байгаад Ж.Эрдэнэбат Ерөнхий сайд байхад үүсмэл орд гэдэг ийм нэг шинэ нэр томъёо орж ирсэн юм. Хэзээ орж ирсэн юм гэхээр би сүүлд нь үзлээ л дээ. Мөн л ингээд төсвийг хэлэлцэж байх явцад Ашигт малтмалын тухай хуульд үүсмэл ордын тухай ойлголт оруулж ирээд, одоо тэр Эрдэнэт дээр байгаа хэдэн овоолгыг миний өмч гээд сууж байгаа байхгүй юу. Жишээ нь нэг компани нь гэхэд 2 тэрбум америк долларын овоолгыг авчхаад одоо миний өмч. Яагаад гэхээр хуулийн дагуу энэ чинь үүсмэл орд байхгүй юу, Эрдэнэтийн ч биш байхгүй юу. Ёёё, энэ их олон хулгайгаа зогсоохгүй юм уу?

Дахиад, Занданшатар дарга бол нэг ийм жижүүрийн хариулт өгч байгаа юм, Байнгын хороон дээрээ ярь л даа, хэлэлцэх үедээ ярь аа гээд. Би нэг юм хариуцлагатай хэлье энэ ард түмний өмнө. Энэ ямар нэгэн Их Хурлын институт бид нар үйл ажиллагаа явуулаад байгаа юм алга байна. Ардын намын 62 хүнтэй, та бүхэн бол энэ бодлогоо гаргаад зөв гэж бодож байгаа бол түүгээрээ яваарай.

Түүнээс биш бид нар Их Хурал дээр үг хэлээд, ард түмэн үг хэлээд санал өглөө, тэд нь бол хууль болохгүй байна. Болох боломж ч үгүй юм байна, болгодог ч үгүй юм байна. Арай бүр хэтрүүлчихсэн байна, та нар. Энэ дээрээ анхаарал тавиарай. Би гурван жишээ хэллээ шүү, хуулийн хулгай. Дараа нь ингээд ярих гэхээр хууль нь ингээд гарчихсан байхгүй юу, хуулийн дагуу л ярьж байна шүү дээ гээд. Хуулийг нь яаж гаргасан юм, хулгай. Яг ингээд Хөгжлийн сайдыг шадар сайд болгож болно. Хуулиа өргөн бариад тэрийгээ тусдаа ярь л даа. Улсын төсөв яриад улсын төсвийг ирэх жил хэдүүлээ яаж амьдрах вэ, өчнөөн өр зээлтэй болох нь гэж байхад нь шадар сайд хажуугаар нь хусаж байдаг, Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулаад юм хусаж байдаг. Энэ чинь гишүүд энэ дээр



анхаарал төдийлөн өгдөггүй байхгүй юу. Үндсэн асуудал дээрээ, төсөв мөнгөн дээрээ л ярьж явахад нэг мэдэхэд л нэг ийм юм ингээд гарчихсан байдаг. Энэ дээрээ та нар анхаарал тавихгүй юм уу? Энийгээ засаж залруулахгүй юм уу? Энэ маш буруу юм явж байна. Анхаарал тавиарай, баярлалаа.

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн санал хэллээ. Тэгээд би энэ хууль, эрх зүйн дүгнэлт гаргасан лавлагааг танилцуулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл дээр бол эрх зүйн дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэж байгаа. Холбогдох Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль, тогтоолын төслийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол тухайн Байнгын хорооны дарга эрх зүйн дүгнэлт хийлгэх төсөл, тодорхой зүйл хэсэг заалт гишүүний гаргасан саналын томъёоллын талаар албан бичгээр Тамгын газарт хүргүүлнэ. Энийг хүлээж аваад хуулийн асуудал хариуцсан газар дараах асуудлаар эрх зүйн дүгнэлт гаргана.

Тухайн улс тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх, хэрэв тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон хуульд нийцээгүй гэх гэж эрх зүйн дүгнэлт гаргасан бол ямар хуулийн аль заалтад нийцэхгүй байгаа талаар, түүнчлэн тэдгээрийн үндэслэлийг тайлбарлах, тухайн төслийн тодорхой зүйл хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, хэрэв зөрчилтэй бол түүнийг тодорхойлж залруулах аргыг санал болгох, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль зүйл хэсэг заалтыг хамруулсан эсэх, хэрэв бүрэн биш бол орхигдсон хууль зүйл, заалтыг заах гээд ингээд ийм эрх зүйн дүгнэлт гаргахаар Байнгын хороо шийдвэрлээд эрх зүйн дүгнэлт гаргаад ингээд танд хүргэчихсэн учраас, Үндсэн хуулийн зөрчилтэй байна гэсэн дүгнэлт гарсан учраас бид нар чинь энийг хэлэлцэх, хууль зүйн хувьд хуулиа дагаж мөрдөхөөс

өөр замгүй болсон байна гэдгийг танилцуулъя.

Ингээд Цогтгэрэл гишүүний асуултад Засгийн газар бичгээр хариу өгөх ёстой гэж бодож байна. Ер нь хууль зүйн хувьд Ерөнхий сайд ажлын зайлиггүй шаардлага гарвал зөвлөлийн саналыг харгалзан нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 3.1-д заасан бусад ажлын өдөр зарлан хуралдуулах болно. Даргын дэргэдэх зөвлөлийн саналыг харгалзан хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөлт оруулж болно. Ерөнхий сайдыг тодорхой сэдвээр мэдээлэл хийх шаардлагагүй гэж үзвэл мэдээллийн цагт энэ хуулийн 109.1-д заасан сэдвийн хүрээнд гишүүдийн тавьсан асуултад шууд хариулт өгөх ажлыг зохион байгуулж болно. Цаг үеийн шинжтэй, тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд мэдээлэл хийх шаардлагатай бол хуулийн 109.1-д зааснаас өөр өдөр хийж болно.

Ажлын зайлиггүй шаардлагын улмаас Ерөнхий сайд, холбогдох Засгийн газрын гишүүд гадаад, дотоод томилолттой, хүндэтгэх шалтгаантай бичиг ирүүлсэн бол хойшлуулаад явсан ийм хуучин дэгтэй. Өмнө нь ч гэсэн тэгдэг байсан. Энэ Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай 10 дугаар сарын 19-ний өдөр 24/20 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дээр бол Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанд намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хийх Ерөнхий сайдын мэдээллийг албан зайлиггүй шаардлагыг харгалзан хойшлуулж өгөхийг хүсье гэсэн ийм бичиг ирсэн байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Гишүүд үг хэлж дууслаа. Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн сайд,

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Хүрэлбаатар сайдыг индэрт урьж байна.

**Ч.Хүрэлбаатар:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу Ерөнхий сайдын “Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар” нэгдсэн хуралдаанд хийх мэдээллийг Та бүхэнд танилцуулж байна.

Уг танилцуулгад нэгдүгээрт макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, хоёрдугаарт богино хугацаанд экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар, гуравдугаарт макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, дөрөвдүгээрт гадаад хүчин зүйлс, үүсэж болзошгүй эрсдэлүүдийн талаарх мэдээллүүдийг оруулж танилцуулж байчна.

**Нэг. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд**

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн 2022 оны эхний хагас жилийн өсөлтөөс хөдөө аж ахуйн өсөлтийн суурийн нөлөөг хасаж тооцвол өсөлт 0.1 хувь болж буурахаар байна. Иргэдээ цар тахлын эсрэг вакцинжуулалтад богино хугацаанд хамруулж, цар тахлын үеийн эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааны хязгаарлалтыг харьцангуй эрт чөлөөлсөн нь дотоодын эдийн засгийн идэвхжиллийг нэмэгдүүлж худалдаа, үйлчилгээний салбар өсөхөд нөлөөлсөн.

Хэдийгээр оны эхний хагас жилд дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, эрэлт тогтвортой байсан ч цар тахлын нөлөөгөөр хилийн боомтуудын үйл ажиллагаа саатаж, түүхий эдийн экспорт эрс буурснаар уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн 28 хувиар агишиж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Үндэсний статистикийн хорооноос сар бүр туришилтын тооцоогоор гаргаж буй дотоодын нийт бүтээгдэхүүний гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт 8 дугаар сарын байдлаар 2.6% болж нэмэгдсэн. Сүүлийн саруудад уул уурхайн бус салбаруудын өсөлт саарч, харин уул уурхайн салбарын үйлдвэрлэл сэргэж байна.

Жилийн инфляц 2022 оны 9 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 13.8 хувьд хүрч, Монголбанкны зорилтот түвшинээс хоёр дахин өндөр байгаа нь эдийн засгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Цар тахлаас өмнө нийт инфляцын 30 орчим хувийг бүрдүүлдэг байсан импортын барааны инфляц 56 хувьд хүрч 26 нэгж хувиар нэмэгдсэн байна. Олон улсын болон дотоодын тээвэр, логистикийн саатлаас үүдэлтэй ачаа тээврийн үнэ нэмэгдэхийн зэрэгцээ төгрөгийн ханш суларсан нь импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх голлох шалтгаан болж байгаа юм. Улмаар үйлдвэрлэлийн орц болдог импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол, үнийн өсөлт нь дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байгаа болно.

Мөнгөний нийлүүлэлт цар тахлын хөл хорио, халдвар хамгааллын дэглэмд айл өрх, иргэдийн орлогыг хамгаалах болон ажлын байрыг хадгалах төсөв, мөнгөний бодлогын хүрээнд цар тахлын өмнөх түвшинээс 30 гаруй хувиар нэмэгдэж, өнөөгийн байдлаар 27-28 их наяд төгрөгт хүрсэн байна. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 8 дугаар

сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар өсөж 22.6 их наяд төгрөгт хүрчээ. Зээлийн өсөлтийн дийлэнхийг худалдаа болон хэрэглээний зээл бүрдүүлж байгаа нь импортыг дэмжиж, төгрөгийн хани сулрах, инфляцад үзүүлэх дарамтыг нэмэгдүүлж байна.

Хөдөлмөрийн зах зээл сэргээж байгаа ч цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна. Вакцинжуулалтыг амжилттай хэрэгжүүлж өмнөх оны сүүлийн хагаст эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааг нээснээр хөдөлмөрийн зах зээл сэргээж эхэлсэн. Ажиллах хүчний оролцооны түвшин энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар нэмэгдэж 59.3 хувьд, ажилгүйдлийн түвшин 0.6 нэгж хувиар буурч 7.8 хувьд тус тус хүрлээ. Ажиллах хүчний тоо 1 сая 263 мянган хүн болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Макро эдийн засгийн гадаад нөхцөл байдал тогтворгүй, эмзэг хэвээр байна. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж, гадаад валютын албан нөөц буурч, төгрөгийн хани суларч байгаа нь эдийн засагт тулгамдаж буй дараагийн асуудал болж байна. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 оны эхний 8 сарын байдлаар 1.5 тэрбум ам.долларт хүрчээ.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээнүүдийн үр дүнд уул уурхайн түүхий эдийн экспортын биет хэмжээ бодитойгоор нэмэгдэж байгаа хэдий ч Монгол улсад орох валютын бодит орлого, ялангуяа нүүрснээс орох орлого хэт багассан нь төлбөрийн тэнцлийн алдагдлын нэг гол шалтгаан болж байна. Импортын өсөлтөд тээврийн зардал, нефтийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт голлон нөлөөлж байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэнээр гадаад валютын албан нөөц

оны эхнээс 1.6 тэрбум ам.доллороор буурч 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 2.8 тэрбум ам.долларт хүрээд байна. 8 дугаар сард Монгол улсын валютын нөөц 2.6 тэрбум доллартой харьцуулж үзвэл 9 дүгээр сард валютын нөөц өссөн дүн ажиглагдаж байна. Төгрөгийн ам.доллартой харьцах харьцах албан хани 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар 3,374 болж, оны эхнээс 524 төгрөгөөр буюу 18 хувиар сулраад байна. Ам.долларын албан хани болон бэлэн валют арилжааны төвүүдийн ханиийн зөрүү сүүлийн 3 жил дунджаар 4 төгрөг орчимд байсан бол энэ оны 4 дүгээр сард 150 төгрөг, 9 дүгээр сард 200 төгрөгийг тус тус давсан тохиолдлууд гарлаа.

Макро эдийн засгийн гадаад орчны хувьд геополитикийн тодорхой бус байдал, инфляцын өндөр түвшин, цар тахлын нөлөөгөөр ирэх онд дэлхийн эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байгаа нь уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах замаар валютын орох урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Мөн сүүлийн өдрүүдэд Засгийн газрын гадаад үнэт цаасны үнэ унаж, өгөөжийн түвшин өссөн нь цаашид өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд арилжаалах гадаад үнэт цаасны хүү өндөр тогтож, валютын гарах урсгалын эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн инфляцыг хязгаарлах хүрээнд хөгжингүй орнууд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь хөгжиж буй орнууд шинээр бонд гаргах, арилжааны зээл авах хүүг нэмэгдүүлэх давхар эрсдэлийг бий болгохоор байна. Эдгээр нөхцөлүүд нь нэн тэргүүнд Монгол улсад орох валютын бодит урсгалыг нэмэгдүүлэх, улмаар зээлжих зэрэглэлийг бууруулахгүй байх, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх зайлиггүй шаардлагыг бий болгож байгааг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.



**Хоёр. Богино хугацаанд экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар та бүгдэд танилцуулъя.**

Засгийн газар богино хугацаанд яаралтай эхлүүлж, ирэх оны эхний улиралд бодитой ажил хэрэг болгох арга хэмжээнүүдээ тодорхойлон хэрэгжүүлж эхлээд байна. Нэн тэргүүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос орох валютын бодит орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг тогтоолоор баталж хэрэгжилтийг хангуулах ажлыг эхлүүлээд байна.

Дээр дурдсанчлан уул уурхайн түүхий эдийн экспортын биет хэмжээ бодитойгоор нэмэгдэж байгаа хэдий ч Монгол улсад орох валютын бодит орлого, ялангуяа нүүрснээс орох орлого хэт бага байгаа нь төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэх нэг гол шалтгаан болж байна. Гаалийн ерөнхий газрын албан мэдээгээр 2022 оны эхний 8 сарын байдлаар уул уурхайн экспортоор тэргүүлэгч 10 компанийн гаальд бүртгүүлсэн экспортын дүн нь 5.5 тэрбум ам.доллар байгаа боловч Монголбанкнаас гаргасан тайлан мэдээгээр эдгээр компаниудад 2.9 тэрбум ам.доллар валютын бодит орлого орж 2.6 тэрбум ам.долларын зөрүү үүссэн байна. Энэхүү 2.6 тэрбум долларын 2.3 тэрбум ам.доллар нь нүүрс экспортлогч 4 аж ахуйн нэгжид хамаарч байгаа юм.

Энэ зөрүүг үүсгэж байгаа гол дөрвөн шалтгаан нь нэгдүгээрт ашигт малтмалын борлуулалтын орлогыг өнгөрсөн онуудад урьдчилан авч зарцуулсан, хоёрдугаарт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болон хөрс хуулалтын ажлын төлбөрийг мөнгөөр биш, ашигт малтмалаар барагдуулж байгаа, гуравт гаалийн статистик мэдээг жишиг үнэ ашиглан бүртгэдэгтэй холбоотой бүртгэлийн зөрүү, дөрөвт нүүрсийг зах зээлийн бодит үнээс доогуур борлуулсан зэрэг байна. Эдгээр шалтгаануудыг арилгах тогтолцооны шинэчлэл бий

болгох болон богино дунд хугацаанд валютын бодит орлогыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээнүүдийг тусгасан Засгийн газрын тогтоол батлагдаж, хэрэгжилтийг хангуулах ажил эхлээд байна.

Тухайлбал, Ашигт малтмалыг олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах зэрэг бүх дамжлагуудад төлбөрийн баримт үүсгэх, холбогдох гэрээнүүдийг гааль, татварын нэгдсэн цахим системд бүртгэдэг тогтолцоог бүрдүүлнэ. 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс зөвхөн энэ тогтолцоонд бүртгэгдсэн ашигт малтмал экспортлогдох боломжтой болно. Ашигт малтмалыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулах уул уурхайн биржийн тогтолцоог 2023 оны 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлнэ. Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалыг хилийн үнээр худалдан борлуулж, ачаа тээврийн хил нэвтрэх зөвшөөрлийг өөрсдөө олгодог болно. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй хөрс хуулалт, олборлолт, тээвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгүүлж “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулна. Төрийн өмчит компаниуд Засгийн газрын ишигдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй гэрээ шинээр байгуулахыг хориглож, өмнө нь хийгдсэн ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой нууц гэрээ хэлэлцээрийг нууцаас гаргаж ил тод болгох, Төрийн өмчит компаниудын төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй гэрээ, төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээ, төлбөр нь нэн даруй хийгдэх гэрээнүүдийн ачилт, тээвэрлэлт, экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах зэрэг төлөвлөгөөт үүрэг даалгаврууд өгөгдсөн болно. Мөн гадаад валютын орох урсгал, валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ашигт

малтмал олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын олборлолт, экспортын тасралтгүй үйл ажиллагаа хангагдахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

Тус тогтоол батлагдсанаас хойш сүүлийн хоёр 7 долоо хоногийн хугацаанд нийт 260.6 сая ам долларын гадаад валютын орлого орж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлсэн эерэг үр дүн гарч байна. Цаашид уг тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулж, төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр 2023 оны эхний хагас жилдээ багтаан төлбөрийн тэнцэлд үүсээд буй гадаад валютын ханшийн дарамтыг бууруулах боломж бүрдэнэ гэж төсөөлж байна.

### **Гурав.Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого**

Засгийн газраас 2023 оны төсвийн төслийг өргөн барихдаа богино хугацаанд яаралтай эхлүүлж үр нөлөө нь 2023 оны сүүлийн хагас жилийн эдийн засгийн үзүүлэлтэд эерэг өөрчлөлтүүд бий болгох болон дунд хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдээ тодорхойлж төсвийн төслийн танилцуулгад тусгасан. Эдгээр бодлогын арга хэмжээнүүдийг бодитойгоор хэрэгжүүлснээр ирэх онд эдийн засгийн өсөлтийг 5 хувьд хүргэх, инфляцыг Монголбанкны зорилтот түвшин болох 8 хувьд хүргэх, хөдөлмөрийн зах зээлийг цар тахлын өмнөх түвшинд хүргэж сэргээх төсөөлөл, төлөвлөгөөтэй байна. Энэ хүрээнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийг онцлон дурдвал:

Нэг.Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсвийн бодлогын хүрээнд 2023 оны төсөвт шинээр эхлэх хөрөнгө оруулалт тусгахгүй, төсвийн алдагдлыг 2022 оны батлагдсан түвшинээс бууруулж, ДНБ-ий 2.8 хувьтай тэнцэх хэмжээнд хязгаарлах замаар төсвийн

хатуу бодлого хэрэгжүүлнэ. Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах хүрээнд мөнгөний бодлогыг чангаруулах шаардлагатай. Энэ бодлогыг дэмжих хүрээнд төв банк валютын ханшийг зах зээлийн зохистой зарчмаар тогтоох, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, банкны салбарын реформыг оновчтой зохион байгуулж, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

Хоёр.Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэж нэмэгдүүлнэ. Ингэхдээ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт, тээвэрлэлтийн үр ашгийг сайжруулах шаардлагатай. Мөн түүнчлэн боомт, тээвэр, логистикийн үйл ажиллагааг сайжруулах бодлогын хүрээнд боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал, Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлэг терминал, ачаа болон зорчигч тээврийн барилга байгууламж байгуулах замаар нэмэгдүүлнэ.

Гурав.Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг ил тод болгоно. Уг арга хэмжээний хүрээнд уул уурхайн биржийн тогтолцоог яаралтай нэвтрүүлж, нүүрсний борлуулалтын ил тод байдлыг нэмэгдүүлж далд эдийн засгийг бууруулах, төрийн өмчийн уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг ил тод болгож хяналтын зөв тогтолцоог мөн бий болгоно.

Дөрөв.Уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинийг нэг шат ахиулна. Энэ хүрээнд уул уурхайн салбарт газрын тос боловсруулах үйлдвэр, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр зэрэг төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

Тав.Эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй эрчим хүч, тээвэр, санхүүгийн салбаруудад либералчлал,

реформыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. Эрчим хүчний салбарт хэрэглэгчид өөрийн хэрэглээндээ тохируулга хийх боломжийг олгож, цахилгаан, дулааны зохистой хэрэглээг дэмжсэн ухаалаг, шударга, зөв төлбөрийн тогтолцоог бий болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар либералчлалыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Тээврийн салбарт төмөр зам, агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ нэгдсэн зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд мэдээллийг нээлттэй болгосноор бизнес, үйл ажиллагааны төлөвлөлтөө зөв тодорхойлох боломжууд бий болгоход чиглэсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлнэ.

Банкны салбарын реформ, өрсөлдөөнийг дэмжих хүрээнд гадаадын банк Монгол Улсад салбараа нээх процессыг хялбаршуулж, санхүүгийн салбарт өрсөлдөөнийг дэмжсэн зөв тогтолцоог бүрдүүлнэ.

Зургаа.Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжинэ. Төрийн хүнд суртлыг бууруулж, төрийн бүх шатны байгууллагаас олгодог бүх төрлийн тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахим тогтолцоонд шилжүүлж, бизнес эрхлэгч зөвшөөрөгдсөн чиг үүргийнхээ хүрээнд холбогдох стандартуудыг ханган үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хүний оролцоогүй үнэлдэг, ил тод, өрсөлдөөнийг дэмжсэн ухаалаг орчныг бий болгоно. Түүнчлэн, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэлийн салбаруудыг татварын болон бусад бодлогын арга хэрэгслээр түлхүү дэмжинэ.

Долоо.Санхүүжилтийн эх үүсвэр, төрлийг нэмэгдүүлнэ. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр нээлттэй хувьцаат компаниудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, хариуцлагыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийж, зах зээлд оролцогчид, хувьцаа

эзэмшигчийн эрх ашгийг хамгаалсан, ил тод, хариуцлагатай, тогтвортой орчныг бий болгоно. Мөн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн салбарыг хувийн хэвшлийн өрсөлдөөнийг дэмжих замаар хөгжүүлнэ. Даатгалын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн санхүүжилтийг дэмжсэн ил тод, найдвартай даатгалын тогтолцоог бий болгох, даатгалын салбарын хөрөнгийн удирдлагын менежментийг сайжруулах болно.

Найм.Боомт, тээвэр, логистикийн үйл ажиллагааг сайжруулах. Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр 2023 онд Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлэг терминал, ачаа болон зорчигч тээврийн барилга байгууламж байгуулах ажлуудыг хэрэгжүүлнэ. Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулна.

**Дөрөв. Гадаад хүчин зүйл, эрсдэлийн талаар**

Цар тахал, дайн, геополитикийн хямралт нөхцөл байдал үүссэн сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, эдийн засгийн өсөлт саарч, хөдөлмөрийн зах зээлийн идэвх суларсан байгаа нь олон улсын хэмжээнд стагфляцын нөхцөл байдал бий болсныг харуулж байна. Үүсээд буй гадаад нөхцөл байдлаас шалтгаалан тохиолдох эрсдэлүүдийг дараах байдлаар тоймлон дүгнэж байна.

Төв банкнуудын бодлогын хүү нэмэгдсэнээр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширах, түүхий эдийн үнэ буурах, шинээр гаргах гадаад үнэт цаасны хүү өндөр тогтох эрсдэлтэй байна. Дэлхийн олон улс орны төв банкнууд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь дэлхий дахины эдийн засгийн сэргэлт удааширах хүлээлтийг бий болгож байна. Олон улсын валютын сан 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2.7 хувь, Дэлхийн банк 2.9 хувь байхаар төсөөлсөн. Зарим олон улсын байгууллагууд 2023 оны

эдийн засгийн нөхцөл байдлыг дэлхийн санхүүгийн хямрал болон цар тахал тохиосон жилүүдийг эс тооцвол 2001 оноос хойших хамгийн тааруу байх төлөвтэй байгааг онцолж байна. Энэ нь манай улсад уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах замаар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна. Мөн хөгжсінгүй орнуудын бодлогын хүү өссөнөөр хөгжиж буй орнууд шинээр бонд гаргах, арилжааны зээл авахад хүү өндөр тогтох эрсдэлийг бас бий болгосон.

Украинд болж буй дайны эрсдэл. Дэлхий даяар хүнсний инфляц өндөр хэвээр байх, Европын орнуудад эрчим хүчний үнэ нэмэгдэх, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал нэмэгдэх, хөрөнгө оруулалт буурах зэрэг эрсдэлүүд хэвээр хадгалагдахаар байна. Дэлхийн улс орнууд ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнүүд хэрэгжүүлж байгаа нь манай улсын ОХУ болон Европоос импортолдог дотоодын аж үйлдвэрлэлийн орц болдог стратегийн шинжтэй бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах, тэдгээр бүтээгдэхүүний үнэ өсөх, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хоригт өртөх эрсдэл. Хөри орнуудыг хамарсан геополитик, цар тахлын “тэг ковид” бодлого үргэлжилж энэ үед өрийн менежмент хийх шаардлага тулгарч байгаа нь зээлжих зэрэглэл буурах, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Иймд манай улс олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөх, ойлголцох, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудаа сайтар бэлтгэх нь зүйтэй. Гадаад зах зээл дээрх тодорхой бус байдал өндөр байгаа хэдий ч Монгол Улсын Засгийн газар дээр дурдсан бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр макро эдийн засаг

тогтворжиж, экспортын орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу Ерөнхий сайдын “Макро эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр баримтлах бодлого, экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар” нэгдсэн хуралдаанд хийх мэдээллийг Та бүхэнд танилцууллаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар Баянзүрх дүүргийн 35 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Эрхэм хүндэт ахмадууд та бүхэнд.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Сангийн сайд Болдын Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Барилга хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар, Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Батмөнхийн Батдаваа, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Санжаагийн Наранцогт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Сархадын Зулхар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга БатИрээдүйн Анар, Эдийн засаг,



хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Идэшийн Батхүү.

Мэдээлэлтэй холбогдуулж Эдийн засаг, хөгжлийн сайд болон ажлын хэсгээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү. Нанзадын Наранбаатар гишүүнээр тасаллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Асуулт, үг нэг.

**О.Цогтгэрэл:** Макро эдийн засгийн тогтворжилт гэдэг сэдвээр мэдээлэл хийж байна л даа. Тэгэхээр ямар ч байсан макро эдийн засаг маань тогтворгүй болчихсон гэдэг нь бол одоо ингээд тодорхой тал талдаа хүлээн зөвшөөрч байна. Тэгэхээр энэний яг үндсэн нь юунаас болчихов оо? Гадаад, дотоод нөхцөл байдал гэдэг дээр бид нар ихэнхдээ гадаад нөхцөл байдал руу, КОВИД руу л шалтгааны шалтгийг чихдэг. Гэтэл яг бодит байдал дээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд гадаад нөхцөл байдал, эрдэс бүтээгдэхүүний эрэлт, үнийн байдал ямар байсныг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ магадгүй жингийн туухай дээр тавибал дотоод нөхцөл байдал, дотоод бодлогын алдаа энэ дээр энэ макро эдийн засгийг тогтворгүй болгосон гэдэг нь бараг л харагдана. Яагаад гэвэл сүүлийн дөрөв, тавхан жилийн хугацаанд төсөв 2 дахин томорчихсон. Энийг дагаад төсвийн алдагдал сүүлийн 3 жилд 10 их наядын алдагдалтай төсөв баталчихсан. Энийг дагаад тэр хэмжээгээр өр зээл нэмэгдэж, өрийн ачаалал одоо ирэх жилийн төсөвт их наяд гарангаар нэмэгдээд явж байна. Тэгэхээр энэнтэй холбоотой хоёр, гурван асуулт байгаа юм.

Нэгдүгээрт нь энэ төсвийн алдагдалтай холбоотой. Төсвийн алдагдлыг энэ жил 1.5 их наяд, энэ нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн хязгаарт байна гээд байгаа юм. Тэгэхээр би Эдийн засгийн сайдаас асуух гэж байгаа нь Ирээдүйн өв сан гээд тусдаа хуулиар зохицуулагддаг, тэнд хуримтлагдсан байх ёстой 1.5 гэж бараг

санаж байна, дахиад их наяд төгрөгийг төсөв рүү татаж оруулж ирж байгаа юм. Энэ чинь яг бодит байдал дээр 1.5 их наядын алдагдал чинь 3 их наяд болчихоод байгаа юм биш үү?

Нөгөө талаараа төсвийн хэмнэлтийн хууль олон зүйл ярьчхаад өнгөрсөн жил 18 их наяд байсан төсвийн зарлага чинь өнөөдөр 20 их наяд. Энэнээс 1.5-ыг хасаад алдагдал гэж үзүүлээд байгаа болохоос, бодит байдал дээр дахиад 18-ыгаа 20 их наяд болгоод нэмчихсэн байна шүү дээ. Тэгэхээр 1.5 дээр 1.5-ийг нэмээд 3 их наяд, дээр нь 2-ыг нэмбэл бодитоороо өнгөрсөн жилтэй харьцуулахад 5 их наядын алдагдалтай төсөв батлагдах төсөв орж ирээд байгаа юм биш үү? Та нар энийг өөрөө тайлбарлаж магадгүй л дээ. Тэгэхдээ Ирээдүйн өв санд байх ёстой, 30 жил хүрэхгүй гэсэн мөнгийг авч ирээд төсөв рүү оруулаад төсвийн орлого зарлагадаа тавьчихаж байна. Энэ дээр энэ төсвийн алдагдал чинь бодит байдал нь ийм өндөр байгаа юм биш үү? Дахиад яг өнгөрсөн 3 жилийн төсвийн алдагдал чинь тэр чигээрээ үргэлжилж байгаа юм биш үү гэдэг.

Хоёрдугаарт нь Засгийн газрын өртэй холбоотой нэг мэдээлэл дахиад тодруулах гэсэн юм. Би бас өмнө нь олон удаа асуугаад ерөөсөө хариулт авч чадаагүй. Засгийн газрын үүрэг гэдэг 8.4 их наяд дотор чинь Монголбанкныхыг оруулахгүй байна, Хөгжлийн банкныхыг оруулахгүй байна, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг оруулахгүй байна. Энийгээ оруулаад тооцвол хэд болох вэ? Зөвхөн Засгийн газрынх гэдэг, энэ чинь Монголын төр хариуцаж байгаа өрийг. Энэн дээр яг таны хувийн байр суурь ямар байна вэ? Янз бүрийн мэдээллүүдээр Дэлхийн банк Монгол Улсыг ДНБ-ийхээ 90 хувьтай, бараг 92 хувьтай тэнцүү өртэй болчихлоо гэсэн мэдээлэлтэй санал нийт нийлэх үү? Засгийн газар бол 50 хувьтай л гэж хэлдэг. Тэгэхээр 2 дахь асуулт нь.

Гурав дахь нь экспортыг бүрдүүлж байгаа бүтцийг харахаар бараг 97 хувь нь эрдэс бүтээгдэхүүн, уул уурхайн бүтээгдэхүүн. Энэ 97 хувь нь бараг бүгдээрээ ерөөсөө түүхий эд хэлбэрээр гарч байгаа байх. Энэ гарч байгаа бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, дахиад энэн дээр боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх чиглэлээр яг энэ мэдээлэл болоод ер нь 2023 оны бодлого чиглэлд ямар бодлогын шийдлүүд орж байгаа вэ? Зөвхөн нөгөө шороогоороо, нүүрсээрээ ачаад байдаг, баяжмалаараа ачаад байдгийг боловсруулалтын түвшин яаж нэмэгдэх юм, эндээс яаж экспортын орлого яаж нэмэгдэнэ гэж тооцож байгаа вэ? Ийм 3 асуулт байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар.

**Ч.Хүрэлбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Би энэ эдийн засагтай холбоотой, үйлдвэрлэлтэй холбоотой асуудал дээр хариулъя. Төсвийн алдагдал, өртэй холбоотой зүйлийг Сангийн сайд хариулах байх аа гэж бодож байна. Ер нь Монгол Улсын эдийн засгийн байдал амаргүй байгаа. Энэ нь өөрөө үндсэн хоёр шалтгаантай. 3 жил үргэлжилсэн цар тахал, одоо Украйнд болж байгаа дайн хоёрын нөлөө бол нийтдээ дэлхийн улс орнуудын эдийн засгийг хүндрүүлж байгаа юм. Валютын сан бол дэлхийн эдийн засгийн өсөлтийг анх 4.6 хувь гэсэн их өөдрөг төсөөлж байсан бол одоо үүнийгээ бараг 80 хувь буулгаад 2.7 хувь болно гээд тооцоо гаргаад ирчихсэн байгаа. Тэгэхээр Монгол Улсад тохиолдож байгаа зүйл бол дэлхийн бусад оронд мөн ялгаагүй тохиолдож, бүгдээрээ л бодлогын хүүгээ өсгөх, төсвийн алдагдлаа бууруулах чиглэлээр, бид бүгд нарын ярих гэж байгаа зүйл бол бусад дэлхийн улс орнуудад мөн адилхан л яригдаж байгаа юм. Тийм учраас ийм бол байгаа шүү гэдгийг би бас хэлье.

Нэг зүйл дээр бол санал нэг байгаа юм. Бодлого дээрээ алдаа гаргасан уу гэвэл гаргасан. Өнгөрсөн оны буюу 2021 оны төгсгөл дээрээс эхэлж эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж явах байсан. Тухайлбал, бодлогын хүүгээ нэмэгдүүлэх шаардлагатай байсан. Тэр үед бол нэмэгдүүлээгүй. Юу гэж үзэж байсан юм бэ гэхээр бодлогын хүүг нэмэхгүй, яг одоо байгаагаараа явна, ингэвэл бид нар эдийн засгийн өсөлтийг хангаж чадна гэж тухайн үедээ яг эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж байгаа хүмүүсүүд үзсэн. Энэ нь өөрөө алдаа байсан. Тийм учраас Цогтгэрэл гишүүнд тэрэн дээр бол бодлогын алдаа байсан гэдгийг би хэлье. Тэгж Их Хурлын гишүүн байхдаа ч бас энэ зүйл алдаа болж байгааг бол сануулж байсан гэдгийг би хэлье.

Боловсруулалтын түвшин гээр бол сая Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ 2023 оны төсвийг өргөн мэдүүлэхдээ үндсэндээ бодлогын урьд өмнө яригдаж байгаагүй цоо шинэ нэг зүйлийг хэлсэн. Энэ нь бол алийн болгон Монгол Улсад газрын баялгаа ухаад тэр чигээр нь гаргадаг байх юм бэ, алийн болгон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдээ хэрэглэхгүй үнэгүйдүүлж явдаг юм бэ, ер нь одооноос эхлээд энэ боловсруулалтын түвшинд уул уурхай болон хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл дээрээ нэмэгдүүлье гэдэг ийм бодлого гаргасан. Үүнтэй холбоотойгоор газрын тос, зэсийн баяжмал, гангийн үйлдвэрлэл зэргийг хийх энэ ажлууд бэлтгэл ажлууд бол яригдаад хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай ярих яриа, яриа хэлцлүүд явагдаж байгаа гэдгийг бас нэгдүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт нь бол хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтыг үйлдвэрлэл боловсруулах түвшнийг ахиулахын тулд яг энэ салбарт оруулж ирж байгаа тоног төхөөрөмжийн гаалийн татварыг тэглэх хууль, хөрөнгө оруулалтын сангуудын татварыг бууруулах зэрэг ийм татварын

холбогдох өөрчлөлтүүдийг мөн өргөсөн байгаа гэдгийг хэлье. Ингээд төсвийн алдагдалтай холбоотой өртэй холбоотой бусад зүйлийг Сангийн сайд хариулах байх аа.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын гадаад өрийн асуудал бол бид хуулиараа заасан тэр томъёоллоороо бид тайлагнаад явдаг. Харин Монгол Улсын нийт өр Засгийн газрын өр болон бусад аж ахуйн нэгжүүүүдийн өр, энийгээ бол бид нар эрсдэлийнхээ тооцоололдоо оруулаад тооцоод л явдаг шүү дээ. Энэ дотор нууц өр гэж байхгүй. Гагцхүү яг эрсдэлтэй тооцоолол хийхдээ алийг нь яаж авах вэ гэдгийг л бид нар харж байгаа юм. Засгийн газрын өр гэж тайлагнахдаа бол бид Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу л Засгийн газар санхүүгийн хариуцлага хүлээх үүрэгтэй. Тэр өрүүдийг оруулаад л тооцдог.

ОУВС, Дэлхийн банк зэрэг гадна талаас манайх зээлжих зэрэглэлийг тооцохдоо манай өрөө удирдлагын стратегийн эрсдэлийг тооцохдоо Монголбанкны өр, мөн төрийн өмчийн хамааралтай компаниудын өр зэрэг хүлээж болзошгүй ийм өрүүдийг мөн оруулж тооцоод эрсдэлээ тооцоолоод л явдаг. Энэ тооцооллын л хэлбэрийн асуудал байгаа юм.

**Г.Занданшатар:** Асуулт, үг нэг учраас тодруулгахгүй юм байна шүү дээ. 2.8-уу? Жавхлан сайд гүйцээгээд хариулчихъя. Тэрний өмнө зочид танилцуулаадахъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын багуудын иргэдийн Нийтийн Хурлын дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багийн дарга нар та бүхэндээ тэр ард түмнээ холбож

төлөөлж ажиллах эх үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.

**Б.Жавхлан:** Би асуултад хариулъя. Ирээдүйн өв санг хүүхдүүддээ зориулж хүүхдийн мөнгийг санхүүжүүлж бид 2 дахь жилдээ ингээд явж байна. Энэ жил бол бид ирэх жилийн төсвийг оруулахдаа Ирээдүйн өв сангаас хүүхдийн мөнгийг санхүүжүүлнэ. Мөн хүүхдийн мөнгийг багасгаж байгаа, илүү зорилт руу очуулж байгаа. Эндээс зөрүү гарч байгаа 9 хувийг нь бол ирээдүйн өв сан дээрээ эргүүлээд л хадгалаад, бүр яг мөнгөжүүлээд явах юм байгаа юм. Ингээд аажим аажмаар зорилт руугаа шилжих тусам гарч байгаа чөлөөлөгдөж байгаа эх үүсвэрүүд маань Ирээдүйн өв сан дээрээ хүүхдийн мөнгөнд яг мөнгөн хэлбэрээрээ хадгалагдаад, ингээд шат шаттайгаар Ирээдүйн өв санг суллаад мөнгөжүүлээд явах ийм дунд хугацааны зорилттой явж байгаа.

Тэгэхгүй бол хүүхдийн мөнгө нь 1.5 их наяд болж ирж байгаа юм. Цаашидаа яг ийм механик өсөлтөөрөө ч мөн нэмэгдээд явна. Ийм тохиолдолд төсөв энийг шууд урсгал зардлаар санхүүжүүлэх, энийг даах бол улам их өндөр эрсдэлтэй болж, цаашаа ингээд өргөжөөд тэгээд яваад байх юм. Яг ийм зохицуулалтыг дунд хугацаанд хийхгүй бол таны санаа зовж ярьж байгаа тэр алдагдал маань төсвийн нийт алдагдал маань суурь нь улам л тэлээд явах, цаашидаа бид тэнцлийг алдагдалгүй болгох ойрын хугацааны ямар ч боломжгүй болж ирэх, тэгэхээр дунд хугацааны ийм санхүүгийн зохицуулалт хийх нь зөв гэж ингэж харсан байгаа юм.

**Г.Занданшатар:** Гонгорын Дамдинням гишүүн

**Г.Дамдинням:** Өнөөдөр эдийн засгийн асуудал орж ирж байна. Макро эдийн засаг, микро эдийн засаг гээд ийм чамин ганган томъёоллоор хэлэхээр хүмүүс ойлгодоггүй юм шиг байгаа юм. Би сая тойргийнхоо иргэдтэй дөрөв хоног тасралтгүй тойрч явж уулзаж байгаад ирлээ. Энд бол манай Өргөө багийн ахмад



настан Батаа гуай, малчин багийн Мөнгөн гуай, 4 дүгээр багийн Жаргалсайхан гуай, Гүнсмаа гуай гээд манай энэ ахмадууд бас ард иргэдийн хүсэлт байгаад байгаа юм. Үнийн өсөлт инфляц бол амьдралд үнэхээр хүнд байна. Жишээлэх юм бол манай ахмадууд эрүүл мэндийн даатгалын сангаас 70 хувийн хөнгөлөлттэй зүрх, даралтын эмээ авдаг байсан бол эдийн засаг, сая төсөв өөрчлөгдөөд ингээд ороод ирсэн чинь 30 хувийн хөнгөлөлттэй болоод 500 мянган төгрөгийн тэтгэврийнхээ 270 мянгыг сардаа багадаа өгчхөж байгаа юм гэнэ эмэндээ.

Энэдээс би нэг ийм асуулт байгаа юм. Манай улсын эдийн засаг нүүрснээс л хамаатай шүү дээ. Нүүрсийг нь төрийн өмчийн нэг том компани хийж байгаад дийлэнхийг нь, үлдсэнийг нь нэг хувийн компаниуд ингээд хийгээд явж байгаа байх. Би Уул уурхайн сайдаас сая асуулаа. Өдөрт манай улс хэдэн тонн нүүрс хилээр гаргаж зарж байна аа? 150 мянган тонн нүүрс өдөр болгон гаргаж байгаа юм байна. Энийг зах зээлийн үнээр нь, гаргаж байгаа үнээр нь аваад үзвэл өдөрт дунджаар 15-20 сая америк долларын борлуулалт бид нар хийж байна. Энэ 15-20 сая америк долларын борлуулалт буюу энэ мөнгө хаачиж байгаа юм бэ? Хааччихаж байгаа юм бэ гээд асуухаар нэг л хариулт хэлээд байгаа юм. Off-take гэрээгээр урьдчилаад зарчихсан гэнэ. Тэгээд зарим тоо баримтыг харахаар манай төрийн өмчийн Эрдэнэс Тавантолгой компанийн ирээдүйн 5-7 жилийн борлуулах нүүрсийг аль эрт зараад дуусчихсан гэж ойлгоод байгаа юм. Тэгээд бид нарын энэ хилээр гарч байгаа өдрийн 15-20 сая долларын орлого аль эрт зарагдаад дуусчихсан гэсэн үг. Тэгээд бид нар энэ долларын хани ярих гээд ухаантай юм яриад суугаад байгаа байхгүй юу. Боломжгүй шүү дээ.

Тэгээд би Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, энэ ажлын хэсгийнхнээс хэдэн асуулт байна. Манай нүүрсний борлуулалтын орлого

нэгдүгээрт хааччихаад байгаа юм? Хоёрдугаарт, энэ компанийн өр авлагын хэмжээ ямар байгаад байгаа юм? Бид нар энэ төрийн өмчийн томоохон аж ахуйн нэгжүүдээс ер нь ирэх жилүүдэд энэ жилүүдэд орлого ирэх юм уу? Доллар орж ирэх юм уу, байгаа юу? Энэ компаниудаа бид нар шахаад хөөрхий том том төслүүд, улсын нууц гэдэг хаяг зүүж байгаад төмөр зам руу ч баахан мөнгийг нь хийлгээд л off-take гэрээ гэдэг юм хийлгэчих юм. Нефтийн хоолой барь гээд off-take хийлгэсэн сураг байна, цахилгаан станц барина ч гэнэ үү. Дандаа off-take гэрээ. Off-take гэдэг чинь урьдчилаад зараад хямд үнээр зараад мөнгийг нь аваад ямар нэг юм зарцуулж байгаа байхгүй юу. Энэ аваад зарж байгаа юмнууд нь бүгдээрээ улсын нууц гэсэн хаягтай байгаад байгаа юм л даа. Тэгээд хэдий хэмжээний нүүрсийг энэ аж ахуйн нэгжийг шахаж байгаа та нар ийм гэрээнүүд рүү өгүүлээд, хэр хэмжээний өрөнд оруулчихсан юм бэ?

Хоёрдугаарт энэ компаниудхөөрхий өрөө хэзээ төлж дуусах юм бэ? Гуравдугаарт бид нарт хэдэн сая долларын яг бодит доллар орж ирэх юм? Тэгж байж энэ долларын ханишийн тогтворжилт бий болно шүү дээ. Тэгэхээр энэ мөнгө байхгүй бол бид нар бодлого.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Ер нь бид нар ил тод ярьж явах ёстой. Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн яг балансаас авсан тоонуудыг та бүгдэд уншаад өгье. Авлага 920 тэрбум төгрөгийн авлагатай.

Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас 12 тэрбум төгрөг авах ёстой. Чингис Хаан банкнаас 60.2 тэрбум төгрөг авах ёстой. Эрдэнэс Монгол ХХК-аас 61.4 тэрбум төгрөг авах ёстой. Багануур хувьцаат компаниас 14.5 тэрбум төгрөг

авах ёстой. Монголын төмөр зам ТӨХК-аас 750 тэрбум төгрөг авах ёстой. Тэгээд бусад авлага 22.2. Энийг нэмэхээр 920.4 тэрбум төгрөгийн авлагатай. Авлагаас гадна өглөгтэй. Үүнээсээ 4 дахин их өглөгтэй. Нийт өр төлбөрийнх нь дүн бол 3 их наяд 489.6 тэрбум төгрөг байгаа юм. Гэрээний өр төлбөр гээд 2 их наяд 338.1, гэрээт олборлогчийн төлбөр 130.2 тэрбум төгрөг, гадаад харилцагч нарт өгөх өглөг барьцаа 142 аж ахуйн нэгж дээр 92.4 тэрбум төгрөг, Бондын төлбөр хүүд 804 тэрбум төгрөг, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 30 тэрбум төгрөг, бусад өр төлбөр 93.8 тэрбум төгрөг. Энэ мэдээ бол 2022 оны 9 дүгээр сарын 27-ны байдлаар. Ийм л байна 3 их наяд 489.6 тэрбум төгрөг. Ийм мэдээ байна. Энэ бол өөрийнх нь балансаас нь авсан дүн мэдээ.

Ер нь бол нүүрс борлуулалттай холбоотойгоор Засгийн газар тогтоол гаргасан шүү дээ сая. Энэ нь ямар учиртай юм бэ гэхээр тэр off-take нь урьдчилж гаргаж байгаа нүүрс байна, одоо төлбөрөө өгөгдөөд төлбөр нь орж ирэх нүүрс байна. Эд нарыгаа зохицуулж ачаад валютынхаа урсгалыг нэмэгдүүлье гэдэг ийм агуулгатай тогтоол гарсан. Энэ гараад хоёр 7 хонож байгаа. Үр дүнд нь түрүүн би та бүгдэд танилцуулсан, 260.6 сая америк доллар орж ирээд явж байгаа. Тэгэхээр энэ тогтоолыг цаашид бүрэн хэрэгжүүлэхийн тулд Эдийн засаг, хөгжлийн яамны дэд сайд Наранцогт, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарыг оруулсан ажлын хэсгийг энэ яг тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахаар ингээд үүрэг чиглэлүүд өгөгдөж байгаа. Ингээд энэ тогтоолынхоо хэрэгжилтийг бид нар хангуулаад ажиллаад байвал юу ч гэсэн энэ валютынхаа нөөцийг нэг их хүндрүүлээд байхгүйгээр зохицуулаад явчих болов уу гэсэн ийм итгэл үнэмшил байна.

Хамгийн гол нь энэ дээр Монголбанк бас бодлогоо нийцүүлэх учиртай. Орж ирж байгаа долларыг тэр чигт нь гаргаж туугаад байвал бас валютын нөөц бүрдэхгүй шүү дээ. Эсвэл ханшаа хиймлээр бариад байвал бас бүтэхгүй. Янз бүрийн компаниудад хямдхан үнэтэй доллар зараад байвал бас бүтэхгүй. Эрдэнэс Тавантолгой энэ Засгийн газрын тогтоолыг биелүүлэхгүй бол бас бүтэхгүй. Тийм учраас энэ тогтоолоо хэрэгжүүлэх ажил саяын нэр дурдсан ажлын хэсэг байгаа. Тэгээд үр дүн гаргаж ажиллачихна гэж бодож байгаа.

**Г.Занданшатар:** Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Хүрэлбаатар сайд аа, би танаас ерөөсөө ганцхан л тоо тодруулаад асуучихъя. Энэ компанийг тал талаас нь шахаж байгаа хөөрхий тэр хүмүүсийг хэдий хэмжээний off-take буюу урьдчилж зарсан гэрээ хийлгэчихсэн юм бэ? Яг тоог нь хэлээд өгөөч. Энэ өрөө энэ компани төлөхийн тулд ирээдүйн хэдэн жил энэ нүүрсээ дунджаар өгөх юм? Өөрөөр хэлбэл мөнгө орж ирэхгүй гэсэн үг байхгүй юу. Зах зээл рүү энэ мөнгө орж ирэхгүй л гэсэн үг. Энийг нь хэлээд өгчихвөл бид нар бас нэг ойлголттой болчихмоор байгаа байхгүй юу. Тэгэхгүй болурьдчилаад бүх нүүрсийг нь том хэмжээний гэрээнүүдээр хийлгэж заруулаад хилээр гарч байгаа бүх нүүрснүүд нь тоог нь харахаар аягүй их нүүрс яваад байгаа боловч бодит мөнгө орж ирэхгүй болчихоод байна л даа. Тэгэхээр энийгээ яг тодорхой тоогоор нь хэлээд өгөөч.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Нийтдээ Эрдэнэс Тавантолгой компани нийтдээ off-take зургаан гэрээ байгаа гэж үзэж байгаа. Манай дээр бол яаманд сая дөрвөн гэрээ ирүүлсэн, 2 гэрээний мэдээлэл ирээгүй байгаа. Дөрвөн гэрээ гэхээр нэгдүгээрт нь

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, газрын тосны үйлдвэрийн нөгөө нефть дамжуулах хоолой, энэ төмөр замын энүүгээр яасан Богд хаан төмөр зам, тэгээд нэг нүүрс баяжуулах үйлдвэр дээр off-take гэрээ байна гэж байгаа, ийм дөрөв гэж байгаа. Нөгөө 2-ыг нь бол мэдээлэл ирээгүй учраас хэлж мэдэхгүй байна. Дүн нь нийт 3.3 тэрбум америк доллар. Үүнээс 3.3 гэдэг чинь 2.5 гэхээр 800 сая долларын.

**Г.Занданшатар:** Off-take дүн чинь 2.3 тэрбум доллар юм биш билүү? Гүйцээгээд хариулчихъя, Чимэдийн Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Нийт дүн нь off-take гэрээний байгуулсан дүн 3.3 тэрбум америк доллар. Үүнээс үлдэгдэл нь 2.5 тэрбум америк доллар гэдэг чинь 800 сая долларын нүүрс гарсан гэсэн үг.

**Г.Занданшатар:** Off-take чинь уул нь түрүүлж мөнгө авах ёстой шүү дээ. Тэгтэл өөр юманд санхүүжүүлчихсэн байгаад л асуудал байгаад байгаа тийм ээ, мөнгө орж ирэхгүй. Тэр чинь нөгөө нүүрс угаах үйлдвэр, нефть дамжуулах хоолой тэрийг нь тодруулж байна. Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяшаа:** Хүрэлбаатар сайдаас нэг асуулт асууя. Гаднын хөрөнгө оруулалтаа уул уурхайн компаниуд, газрын тосны компаниуд олон арван тэрбум төгрөгийн экспортын бүтээгдэхүүн гаргасан гэсэн тоо баримтыг бид зөвхөн цаасан дээр харж байна. Энэ мөнгө Монголын банкаар орж ирэхгүй байгаа. Зөвхөн урсгал зардал орж ирж байгаа. Энийг би удаа дараа хэлж байгаа юм. Энэ талаар ямар арга хэмжээ авах вэ? Энэ арга хэмжээ авч байж өнөөдөр валютын хомстолын асуудал, эдийн засгийн асуудал чинь сайжирна гэсэн ийм ойлголттой байдаг юм. Энэнд нэг харуулт авчихъя.

Дээр нь, эдийн засгийн асуудал ярьж байна, экспортын асуудал ярьж

байна. Энэ дээр Болорчулуун сайдаас уул нь асуух гэсэн юм байхгүй байна. Тэгэхээр би энэнтэй холбоотой үг хэлчихье. Махны экспортын асуудал өнөөдөр Монголын эдийн засагт хамгийн их нөлөөлж байсан хүчин зүйл байсан. Гэтэл өнөөдөр махны экспорт бүрэн хаагдсан. Өнөөдөр Монголын махыг авдаг ямар ч газар, ямар ч улс орон байхгүй боллоо. Энэ асуудал бол КОВИД ч биш, Украйны дайн ч биш, зөвхөн мал эмнэлгийн байгууллагыг толгойлж байгаа, хүнсний асуудлыг толгойлж байгаа албан тушаалтнуудын гэм буруутай үйлдлээс болсон. Монгол Улс бол КОВИД-той тэмцэж байна гэх нэрийдлийн дор бусад бүх юм хаясан. Шүлхий гэдэг өвчинтэй Монгол Улс тэмцэж, тэрнийг ялж арга хэмжээ авч малаа эрүүлжүүлж ирсэн ийм туршилагатай улс.

Гэтэл энэ КОВИД-ын үед Мал эмнэлгийн ерөнхий газрыг толгойлж байсан, тухайлбал, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Батчулуун гэдэг хүн бол өнөөдөр Монгол Улсын эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байгаа, би. Өнөөдөр Засгийн газар улс орныхоо эсрэг гэмт хэрэг үйлдсэн гээд л их олон юм яриад байдаг. Энэ хүнтэйгээ яагаад наад хариуцлага тооцдоггүй юм бэ? Монгол Улсын экспортыг байхгүй болгосон махны. Хэдэн сар Эмээлтийн мах муу байна, сайн байна гэж хэвлэл мэдээллээр шуугуулаад, тэгээд сүүлд нь махны экспортыг хаагаад, тэгээд өнөөдөр Монгол Улсын махны экспортыг хэвтүүлсэн, дээр нь өнөөдөр Монголын малчдын амьдралыг сүйрүүлээ. Энэ хүнтэй яагаад хариуцлага тооцдоггүй юм? Энэ их том артай хүн гэсэн. Өнөөдөр Авлигатай тэмцэх газар, Засгийн газар, хууль хүчний байгууллага албан тушаалдаа хайхрамжгүй хандсан ийм хүмүүст энэ гэмт хэргийн тухай яагаад өнөөдөр ярихгүй байна аа? Би өнөөдөр Улсын Их Хурлын гишүүний хувьд энэ Батчулуун гээд нөхрийг би Авлигатай тэмцэх газарт өгнө. Яагаад ийм хүн өнөөдөр хариуцлага алдаад, улс орны эдийн засгийг сүйрүүлээд Монгол Улсыг

жинхэнэ элгээр нь хэвтүүлээд байхад тэр хүн өнөөдөр нэг баатар юм шиг тэр намын том артай байж болно оо.

Монгол Улсад шүлхий гарсаар байгаа шүү дээ, өнөөдөр. Ямар ч арга хэмжээ авдаггүй. Тэрнийг нь хэлэхээр бүр их дургуйцдэг, олон байдлаар дургуйцлээ илэрхийлдэг. Ийм юмтай бид нар өнөөдөр тэмцэхгүй юм уу? Засгийн газар сахилга хариуцлагыг, албан тушаалын хариуцлага алдсан хүмүүстэйгээ хариуцлага тооцно гэж удаа дараа ярьж байгаа. Авлигатай тэмцэх газар жинхэнэ ийм гэмт хэрэг үйлдсэн, албан тушаалдаа хариуцлагагүй хандсан, улс эх орны эдийн засгийг сүйрүүлсэн ийм гэмт үйлдэл гаргасан хүмүүстэйгээ яагаад хариуцлага тооцохгүй байна аа? Энэ талаар удаа дараа ярих болно.

Монгол Улсын малын махны экспорт, малчдын асуудал, хөдөө аж ахуйн экспортын асуудал бол өнөөдөр хамгийн чухлаар тавигдаж ирсэн шүү дээ. Энэ дээр бол, би үгээ хэлчихье.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар.

**Ч.Хүрэлбаатар:** Адъяаа гишүүний асуултад хариулъя. Ер нь яг таны хэлж байгаагаар тэр Монголын баялаг борлогдсон бол бүх мөнгө нь арилжааны банканд Монголын банкнуудад орж ирэх тэр хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилготой юм байгаа. Энэ 10 сарын 5-нд батлагдсан Засгийн газрын 362 дугаар тогтоол. Энэ яах вэ гэхээр олборлохоос нь эхлээд хилээр гарах хүртэлх тэр бүх үйл ажиллагаатай холбоотой бүх гэрээг татвар гаалий н нэгдсэн системд бүртгээд авч байгаа юм. Тэгээд энэ системд бүртгэгдээгүй бол нүүрс нь гарахгүй. Гэрээ нь бүртгэгдчихсэн, дүн нь бүртгэгдчихсэн, хилээр гарлаа бол тэр мөнгө нь орж ирсэн байх шаардлагатай. Хэрвээ энэ нь орж ирэхгүй байгаа бол зөрүүгээр нь энэ мөнгө нь хаачихсан юм бэ гэдэг асуудал гарч эхэлнэ шүү дээ. Ийм тогтолцоо бол

бүрдээгүй байсан. Одоо үнийг бүрдүүлээд ингэчих юм бол Монголоос зайлсхийгээд гарах, зугтаах ийм ямар нэгэн боломж бол байхгүй болно. Тэгэхээр ний нуугүй хэлэхэд элдэв улсын хардлага ч алга болно.

Бид нар сая энэ Засгийн газрын тогтоол дээр ажиллаад үзэхэд тэр Оюу толгойн мөнгөнүүд чинь Монголын банканд орж ирдэг л юм байна лээ. Төмрийн мөнгөнүүд а,б-гүй бүгдээрээ орж ирдэг, зэсийнх төлбөрүүд а,б-гүй бүгдээрээ Монголын банкнуудаар орж ирээд эргээд гараад явдаг ийм л тогтолцоотой болчихсон юм байна лээ, ялангуяа. Хамгийн гол зөрүү нүүрсэн дээр гарч ирээд байгаа юм. Тийм учраас энэ хэдийгээр зөвхөн нүүрс гэж заагаагүй бүх ашигт малтмал дээр хамаарах тогтоол боловч гол асуулт нь энэ зөрөө байгаад байгаа хэсгүүд дээр гарч ирээд байна гэж бид нар ойлгож байгаа. Тэгэхээр таны санаа анхаарал тавьж байгаа зүйл бол энэ тогтоолын хүрээнд ер нь шийдэгдчихнэ ээ.

**Г.Занданшатар:** Асуулт, үг нэг учраас тодруулах дэг бол байхгүй юм байна. Содномын Чинзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Чинзориг:** Хүрэлбаатар сайд хариулах юм уу, хоёр, гурван юм тодруулдаг юм уу? Их Хурал чинь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, мах, гурил, бензин тосон дээр нөөц бүрдүүлнэ, үнэ тогтворжуулна гээд хууль баталсан. Энэ хууль маань бас тэгээд бүрэн хэрэгжихгүй байх шиг л байх юм Хүрэлбаатар сайд аа? Түли, шатахуун дээр бол хэрэгжээд нефть импортлогч байгууллагууд, компаниуддаа хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр өгөөд, бензиний үнэ 92-ын үнийг бас тогтвортой хугацаанд бас бариад л байх шиг байгаа юм.

Гурил дээр энэ асуудал ерөөсөө хэрэгжихгүй байна Хүрэлбаатар сайд аа. Одоо бид нар чинь тэр хууль батлагдаж байхад гурилын үйлдвэрүүдэд 100 орчим



тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр олгож, нөөц бүрдүүлнэ, үнэ тогтворжуулна гээд л хууль батлагдсан шүү дээ. Тэгээд Хөдөө аж ахуйн яам, Монголбанкнаас судалгаа аваад үзэхээр гурилын үйлдвэрүүдэд олгох энэ 100 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эх үүсвэр чинь одоогоор олгогдоогүй байх юм. Энэ юутай холбоотой юм? Ингээд Их Хурлын гаргасан шийдвэр хэрэгжихгүй яваад байвал нөгөө нөөц бүрдүүлэх, үнэ тогтворжуулна гээд хууль баталсан энэ хууль маань хэрэгжих юм уу? Бид чинь нөөц бүрдүүлнэ, үнэ тогтворжуулна гээд нийгэм зарлаад хууль баталлаа энэ тэр гээд ингээд нийгэмд нэлээн хүлээлт үүсгэсэн шүү дээ. Нэгэнт Их Хурлаас гаргасан энэ хуулийнхаа хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн газар, Монголбанк нэлээн бас шуурхай ажилламаар байх юм.

Хоёр дахь асуудал нь, энэ үнийн өсөлт, инфляцын түвшин чинь ер нь тэгээд саарах юм уу даа? Би бол одоогийн байдлаар мөнгөний бодлого, эд нар дээр нэг оронтой тоонд оруулна л гээд л байгаа юм. Одоогийн нөхцөл байдлыг чинь харахаар нэг оронтой тоонд орох ямар ч боломжгүй юм шиг л харагдаад байна шүү дээ. Сая Статистикийн газраас гаргасан судалгаагаар 1 сарын дотор талх, гурил, будааны үнэ чинь 21.1 хувь өсчихлөө. Эрчим хүчний сайдын ярьж байгаагаар 11 сарын 1-нээс аж ахуйн нэгж, байгууллагуудад олгож байгаа цахилгааны үнэ чинь 14-28 хувиар өсөх юм байна. Энийг чинь ингээд тооцоо судалгаа хийгээд үзэх юм бол цахилгааны үнэ нэмэгдэхээр суурь үнэ, инфляцад нөлөөлөх нөлөөлөл 1.5-1.7 хувийн нөлөөлөл болж очих нь.

Гурван гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлтөөс чинь болоод ингээд 0.4- 0.5 хувийн сарын инфляцын хүү хувь дээр нэмэгдэж байгаа нөлөөлөл нэмэгдэх нь байна шүү дээ. Ингээд 20 орчим хувиар чинь эдгээр бүтээгдэхүүний чинь үнийн өсөлтөөс чинь болоод инфляц нэмэгдэх гээд байдаг.

Тэгэхээр 13.8 байгаа инфляц чинь оны эцэс рүү ер нь буурахгүй орох нь. Тэгээд ирэх онд энэ инфляцын түвшин буурах тийм төсөөлөл магадлал байгаа юм уу? Та бүхэн юу гэж бодоод тооцоод байгаа юм?

Гурав дахь асуудал, валютын ханиш, ер нь цаашидаа тэгээд тогтворжино гэсэн тийм итгэл, баталгаа байна уу, үгүй юу? Одоо Монголбанканд байгаа валютын нөөц чинь 2.4, 2.5 орчим байх шиг л байгаа юм. Энэ чинь бол үндсэндээ нөгөө 3 сарын л импортын хэрэгцээгээ л дөнгөн данган хангах болох нь байна шүү дээ. Ийм валютын нөөцтэй болчихсон үед бол бид валютын интервенцийн валютын ханшийг тогтворжуулна гэдэг асуудал чинь бас л нэлээн хязгаарлагдмал болох нь л дээ. Тэгэхээр энэ валютын ханиш тогтворжих ийм итгэл үнэмшил одоо байх уу, үгүй юу гэдэг.

Дөрөв дэх асуудал нь Хөдөө аж ахуйн сайд анхаараач. Өвөрхангай аймагт зунлага бол алаг цоог болсон. Зүүн талын гурав, дөрвөн сум, говийн зургаан суманд бас өвөлжил нэлээн хүндрэх нь ээ. Одоо манай Өвөрхангай аймгаас нийтдээ нэг одоогийн байдлаар 700 гаруй малчин өрх гаднын аймгуудад өвөлжинө гэсэн тооцоо судалгаа өгөөд түрүүчээсээ нүүгээд эхэлчихсэн байна. Энэ оторчдыг хөөж туухгүй байх, тав тухтай өвөлжүүлэх, хаваржуулах асуудал дээр Хөдөө аж ахуйн яам бодлого гаргаж, орон нутгийн удирдлагууд чиглэл өгсөн шүү дээ.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар.

**Ч.Хүрэлбаатар:** Эхлээд валютын нөөцийн асуудлаас ярья. 9 сарын байдлаар валют Монгол Улсын валютын нөөц 2 тэрбум 795 сая доллар буюу үндсэндээ 2.8 тэрбум америк доллар гэж хэлж болно. 8 сарын дүнг аваад үзэх юм бол 2.6 тэрбум америк доллар байсан. Тэгэхээр юу ч гэсэн 9 сард бол энэ валютын нөөц бол нэмэгдсэн ийм дүр зураг бол байгаа юм.

Цаашидаа Засгийн газрын тэр тогтоол гарахынхаа хоёр 7 хоногийн өмнө Засгийн газрын тэмдэглэл гарсан шүү дээ. off-take дээр гарч байгаа бүх нүүрсүүдийг зогсоох, урьдчилсан төлбөртэй гарч байгаа нүүрсүүдийг зогсоох, зөвхөн мөнгө нь орж ирдэг гэрээ бүхий нүүрсүүдийг гаргах гэдэг зүйл гарч байгаад, дараа нь тогтоол болгож өөрчилсөн. Тэгэхээр юу ч гэсэн 8-9 сарын хооронд бол валютын нөөц бол ингээж нэмэгдсэн байгаа гэдгийг хэлье.

Үнэ тогтворжуулах хууль баталсан. Яг ний нуугүй хэлэхэд хууль батлаад үнэ тогтворжихгүй гэдгийг тухайн үед бид нар зөндөө ярьсан шүү дээ. Хэрвээ хууль батлаад энэ тогтворжоод инфляц буучихдаг бол дэлхийн бүх орон аягүй амарна шүү дээ, нэг нэг хууль баталчхаад сууж байхад үнэ буучихна. Тэгээд угаасаа тэр нь амьдрал дээр яг бодитойгоор хэрэгжихгүй гэдэг зүйлийг бол бид нар тухайн үедээ ярьсан. Ингээд бусад улс орнуудын туршилагыг хараад байхад үнээ тогтворжуулах мөнгө өгдөг, зээл өгдөг, хөнгөлөлттэй зээл өгдөг энэ арга хэмжээнүүд бүгд бүтэлгүйтсэн байхгүй юу. Одоо ч улс орнуудад бүтэлгүйтэж байгаа яг түүнтэй адилхан би бол тэр үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хууль бол тэр бас л бүтэлгүй л зүйл байсан. Тэгэхээр тэрэн дээрээс бол янз бүрийн юм горьдоод, тэрийг хэрэгжүүлэх гээд зүтгэх бол улам л энэ эдийн засгийг нураах болов уу л гэж бодож байгаа юм.

Дээр нь гурилын компаниудад хөнгөлөлттэй зээл өгье. Хэн, яг шалгуурыг нь даваад явах аж ахуйн нэгж ховор шүү дээ. Ялангуяа энэ КОВИД, дайн гээд хоёр, гурван жилийн хугацааны дараагаар бол шалгуурыг хангаад давахгүй. Нэг нь авчихлаа гэж бодоход, энэний ард талд тэр хүн байгаа, энэ хүн тэр хүний ангийнхан, хүүхдийн хамаатны дүүгийнх нь хүн байгаа юм гэдэг ийм зүйлээр яриад яллаад байдаг учраас энэ банкнууд нь ч тэр, аж ахуйн нэгжүүд нь ч тэр зээлийг авахыг бодохгүй байна шүү дээ. Түүний хооронд зах зээлийн жамаар нь яв гэсэн

байдалтай хүмүүс хандаж байгаа юм. Тэгэхээр бид нар бодит юмыг бодитойгоор нь ярьж явахгүй бол буруу зүйлийг хүчиндэж хийчхээд дараа нь эргүүлээд улс орон даяараа л сенсац болж зарим нь дуудагддаг, адлагддаг ийм л зүйл байна шүү дээ. Нэг нэгийхээ нэр төрд хаа хамаагүй халддаг ийм зүйлүүд гардаг. Тэр бол хэрэгжих магадлал нь бол ерөөсөө анхнаасаа их буруу шүү. Нефтийн компаниудад одоо доллар өгөөд л байгаа гэж байгаа. 100 сая долларын хэрэгцээтэй байхад 200 сая доллар аваад цаашиа 100-г нь дамжуулаад өгдөг ч байхыг хэн ч үгүйсгэхгүй шүү дээ. Буруу юм бол дандаа буруу үр дүнг л авчирдаг гэдгийг би хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Дараа нь Болдын Жавхлан сайд хариулна. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурын Ганхуяг нарын урилгаар Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Би асуултад нэмж хариулъя. Хуульдаа ч нэг асуудал биш юм байгаа юм. Гол нь энэ хуулийн хэрэгжилтдээ л байгаа юм. Энийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг. Тухайлбал, энэ нефтийн бүтээгдэхүүн дээр энэ хуулийн хэрэгжилт маш сайн үр дүнгээ өгсөн. Тийм учраас өнөөдөр түлш, шатахууны үнэ тогтвортой энэ хэмжээндээ байгаа. Ургац хураалтын үед ч энэ нэлээдгүй сайн үр дүнгээ өгсөн, энэ хууль хэрэгжилт болсон.

Сангийн яамнаас бид анх удаа энэ хуулийн хүрээнд шатахуун импортолж байгаа компаниуд дээр Засгийн газрын баталгааг жижиглэнгээр компани тус бүрээр ингээж Монголбанкаар дамжуулж

гаргаж өгсөн байгаа. Энэ маань ч одоо маш сайн үр дүн өгч нефть импортлогч компаниудыг татан авах нөөцөө хоёроос гурван сараар урьдчилж татаж авч нийлүүлэх ийм боломжийг нь бүрдүүлсэн. Ингэж чадсанаараа нийлүүлэлт дээр бол хомсдол гараагүй, улмаар үнийг нь тогтвортой байлгах. Мөн валютын хувьд ч тэр төлбөр тооцоо шилжүүлэхэд хүндрэлтэй байсан, нийлүүлэлт дээр бол ямар нэгэн хүндрэл гарахгүй явах энэ боломжийг Улсын Их Хурлаас баталж өгсөн энэ хууль олгосон байдаг. Энэ хэрэгжилтийг бол ямар ч байсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай Сангийн яам хамтарч энэ нефтийн бүтээгдэхүүний импорт болон үнийг нь тогтвортой байлгах дээр маш сайн үр дүн гаргасан гэж үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд.

**Х.Болорчулуун:** Үнэ тогтворжуулах гэж ер нь хууль баталсан. Сая Хүрэлбаатар сайд хэллээ. Үнэн шүү дээ. Үнэ тогтворжуулаа гэж хууль баталдаг бол дээр бүх л улс орон нь тогтворжуулаад байна. Тэр бол нэр нь ч гэсэн буруу хууль баталсан юм. Тодорхой хэмжээнд дэмжлэг гэхээс биш үнэ тогтворжуулах гэж угаасаа утгагүй. Ер нь зах зээлийн жамаараа явах ёстой юманд бас хэтэрхий төр оролцоод байх нь бол гурил будааны өөрийн зах зээлийн жамаар явах байдлыг бол алдагдуулж байна гэж сая хэллээ, үнэн. Тэгэхээр ерөнхийдөө миний хэлэх үгийг бол Эдийн засаг, хөгжлийн сайд хэлчихлээ шүү дээ. Би энэ дээр бол нэмээд айхтар хэлээд байх юу байх вэ. Харин тэр Монголбанкнаас өгөх 100 тэрбум төгрөг одоо хүртэл өгөгдөөгүй байгаа. Тэрийг өгсөн мэтээр ойлгоод гурилын үнэ өсчихлөө, гураил, будааны үнэ өсчихлөө гээд ингэж бас яриад байгаа шүү. Одоо хүртэл өгөөгүй байгаа тэр, баталсан мөртлөө.

**Г.Занданшатар:** Тодруулга байхгүй. Хууль баталчихаад хэрэгжихгүй

ээ. Тэр өвөлжилтийн бэлтгэл, гурилын үнийн талаар та суусан тийм ээ? Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Дэлхийн эдийн засаг дайнтай холбоотойгоор, КОВИД-той холбоотойгоор бол маш их уналтын нөхцөл байдалд байгаа. Дэлхийн бүх орнууд бүгдээрээ бүсээ чангалж байна, төсвөө хэмнэж байна, төлөвлөлтөө бүх зардлуудаа бүгдийг нь хэмнэх замаар энэ хүндрэлийг даван туулахаар зорьж байгаа. Гэтэл манайх Монгол Улсад эсрэгээрээ байна. Улсын төсөв бол түүхэндээ байгаагүйгээр их нэмэгдсэн. 20.5 их наяд төгрөгийн зардалтай, 19 сая төгрөгийн орлоготой. Тэгээд орлогоо болохоор маш их нүүрс гаргана гэж байгаад өнгөрсөн жил 38 сая тонн нүүрс гаргана гэж байгаад дөнгөж 20 саяыг аваад явж байх жишээтэй. Ирэх жилийн хувьд бол 36 сая тонн нүүрс гаргана гэж байгаа. Орлого талаа их өндөр тавьчихаад, тэгээд зардлаа нэмээд байдаг ийм зүйл маш их явж байна.

Ирэх жилийн хувьд бол хөрөнгө оруулалт 2.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байгаа. Концесст 280 тэрбумыг зарцуулж байгаа. Дээрээс нь гадаадаас авах зээл нь 1.7 их наяд байгаа. Ингээд 5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гарч байна. Энэ хөрөнгө оруулалтын зардал нь яадаг вэ гэхээр 100 хувь урагшаа Хятад руу валют болоод гарч байгаа. Өөрөөр хэлбэл, бараа бүтээгдэхүүний зардалд гарчихна. Дээрээс нь 15 их наяд төгрөгийн урсгал зардлын чинь бараг 50, 60 хувь нь буюу 8 их наяд нь бас дахиад л, манайх чинь өөрөө хэрэглэгч орон, хэрэглээний орон учраас буцаад л ирээд урагшаа бараа бүтээгдэхүүнд төлбөр болоод гарчихна.

Ингээд 13 их наяд төгрөгийн төлбөр ирэх жил яг ингээд валют болоод гарчих юм байна. Энэ нь нэг талдаа Монголбанк нь мөнгөний хатуу бодлого баримтлаад жишээ нь 12 хувийн хүүтэй, цаашидаа хэдийгээр 15 болоод явлаа ч гэсэн өөрөөр хэлбэл валютын ханшийг



тогтвортой болгох, төгрөгийн ханшийг чанга байлгах энэ бодлого чинь ерөөсөө хэрэгжихгүй, ийм нөхцөл байдал руу хөрөнгө оруулалт, зардал чинь. Тийм учраас ирэх жилийн хувьд бол 4000 гараад доллар чинь гараад явах нь гэсэн, бараг 5000 хүрэхээр ийм нөхцөл байдал руу л байна.

Тэгээд энэ төсвийн алдагдал 1.5 их наяд гээд байгаа юм. Гэтэл Ирээдүйн өв санд хуримтлагдах ёстой тэр 1.5 их наядаа зарцуулаад, одоо энэ чинь 3 их наяд болчихоод байгаа шүү дээ. Нэг архичин аав байдаг, хүүхдийнхээ мөнгийг хадгалж хадгалж байгаад ингээд 1.5 сая төгрөг болчингуут нөгөөдөх гэртээ ирэхээрээ бүх мөнгөөр нь архи уучихсан, тэгээд гэртээ ирэхээрээ өө, мөнгө дансанд байгаа гээд ингээд хэлээд байгаатай адилхан л байгаа байхгүй юу. Ийм нөхцөл байдалд аваачна. Тэгээд төсвийн алдагдал 1.5 их наяд гэххээд тэгээд ёс юман дээр ингээд 3.3 их наядын одоо төсвийн алдагдалтай ийм л төсөв орж ирж байгаа. Ирэх жил 1081 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс 80 хувь нь ашиглалтад орохоор ийм хөрөнгө оруулалтын зардлыг тавьсан байна. Энэ яагаад ийм өндөр байгаа юм? Энэнээс болоод урагшаа валют гарах нь энэ нөхцөл байдал чинь маш их эрчимжих юм биш үү? Дээрээс нь та бүхэн одоо ингээд нүүрсний экспортоо өндөр тавьчихдаг 38 сая тонн гээд тавьчихдаг. Гэтэл тэнд чинь.

**Г.Занданиатар:** 1 минут гэж байхгүй байна. Хэн хариулах вэ, үг хэлчихсэн юм уу? Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Үнэн, таны хэлсэн тоо зөв. Эндээс 917 төсөл, арга хэмжээ буюу нийт төсөл арга хэмжээний 86 хувь нь ирэх жил ашиглалтад орно. Өмнө нь бол энэ үзүүлэлт 40 орчим хувьд хүрдэг үү, үгүй юу байсан. Ирэх жил ингэж байгаа юм, яагаад гэвэл дараа дараагийн үнийн өсөлтийн эрсдэлээс сэргийлж байгаа юм.

Та инээх юм байхгүй ээ. Цаашидаа ч гэсэн ер нь хөрөнгө оруулалт хийх, дуусах хугацааг аль болох богинохон, тухайн тухайн жилдээ ашиглалтад оруулаад явж байдаг ийм хөрөнгө оруулалтынхаа бүтэц рүү явж орно. Тийм учраас энэ олон жил сунжирсан дуусдаггүй, анхнаасаа бэлтгэл хангалтууд нь муу байсан, тэрнээсээ болоод олон жил сунжирдаг, олон жил үнийн өсөлтөд өртдөг эндээсээ хэрүүл маргаан, ингээд л хардалт сэрдэлт дагуулдаг ийм хөрөнгө оруулалтын бүтэцтэй, бодлоготой явж болохгүй. Тийм учраас ирэх жил яг энэ сувгаар нэлээдгүй том тохиргоо хийж байгаа гэсэн үг төсөв дээр.

Цаашидаа 24 оноос эхлээд Төрийн хяналтын хууль, Төсвийн хуулиа болчанд мөрдөж, хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг сайтар хангасан, ТЭЗҮ, судалгаа, бүх зүйл нь бэлэн болсон газар нь дэд бүтэц, зураг төсөв, ингээд 24 оноос цаашаа энийгээ сайн баримтлаад явбал хөрөнгө оруулалт бол төсвийн хөрөнгө оруулалт бол бас ихээхэн сахилга баттай, илүү үр дүнтэй, төсөв дээр ямар нэгэн ирээдүйд эрсдэл авчрахгүйгээр ингэж явах бүрэн боломж бүрдэнэ.

Харин таны ярьж байгаа яг валютын төлбөрийн тэнцэл дээр ирэх дарамтуудыг бид шинэ төсвийн хөрөнгө оруулалтуудыг ирэх жил байхгүй хийхгүй байснаар тодорхой хэмжээнд барьж чадаж байгаа юм. Харин энэнээс илүүтэйгээр төсөв дээр ирэх энэ дарамтуудыг багасгах, тэр эрсдэлийг бууруулах үүднээс ирэх жил явж байгаа төслүүдийг ихэнхийг нь дуусгах нь зүйтэй гэж үзсэн байгаа юм.

**Г.Занданиатар:** Чимэдийн Хүрэлбаатар сайд гүйцээгээд хариулъя. Тодруулга байхгүй юм байна.

**Ч.Хүрэлбаатар:** Пүрэвдорж гишүүний болгоомжлол бол үнэхээр зөв. Төсвийн зардлаас хэчнээн доллар болоод гараад явчих юм бэ, тэр чинь эргээд долларын эрэлтийг бий болгоод

төлбөрийн тэнцэл дээр чинь асуудал үүсгэх юм биш үү? Нэн ялангуяа хөрөнгө оруулалт гэж асууж байгаа юм. Тэгэхээр нийт хөрөнгө оруулалтын дүнд та нийтдээ 1.5 их наядыг ярилаа. Таны хэлдэг 1.5 их наядын зээл буюу буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийг хэлж байгаа юм. Тухайлбал, 1.5 дотор чинь таны хэлж байгаа, тэрэн дотор Мянганы сорилтын 380 сая долларын усны үйлдвэр барих, ус цэвэршүүлэх үйлдвэр барих цэвэрлэх байгууламж, Дарханы зам зэрэг томоохон бүтээн байгуулалтуудын чинь тийм хөрөнгө оруулалт бол долларын эрэлт бий болгохгүй юм. Яагаад гэвэл гаднаас авч байгаа буцалтгүй тусламж зээлээр учраас дотооддоо долларын эрэлт бий болгохгүйгээр ороод ирэх юм. Долларын эрэлт бий болгох нь ойролцоогоор нэг тооцоод үзэх юм бол яг энэ дээр бол 3.6 их наяд гэж байгаа. Тэгэхээр чинь 1 тэрбум америк доллар. Нийтдээ 8 тэрбум америк долларын импорттой гэж үзэхэд 1 тэрбум нь яг энэ улсын төсвийн хөрөнгө оруулалттай учраас бас яг ний нуугүй хэлэхэд тийм их бодож байгаа шиг чинь их өндөр юу оруулж ирэхгүй гэж бид нар тооцож байгаа шүү. Тэгээд ер нь бол энэ дээрээ зохицуулалт хийж, нэлээд хяналтад анхаарал бол тавьж явна гэж бодож байгаа.

**Г.Занданшатар:** Асуулт, үг нэг байгаа юм. Хавдисламын Бададьхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Х.Баделхан:** Баярлалаа. Ер дэлхийн хэмжээнд бол эдийн засаг бас хүнд байгаа л даа. КОВИД, КОВИД-ын дараа дайн нь үргэлжлээд, ер нь дэлхийн хэмжээгээр эдийн засаг хүнд байна гэдгийг хүн болгон ойлгож байгаа. Сая Хүрэлбаатар сайдын мэдээлэлд төгрөгийн хани бол оны эхнээс 18 хувиар суларсан гэж мэдээлсэн. Энэ бол ер нь бараа таваарын үнэ өсөөд, ард иргэдийн амьдрал бол ер нь хүндээр тусаж байгаа. Ялангуяа алслагдсан холын аймгуудад бол хүнд байгаа. Одоо гурилын үнэ өсөж

байна. Тухайлбал, нүүрсний үнэ манай аймагт 1 тонн нүүрсний үнэ бол 130 мянган төгрөг, алс бол Булган сумдыг хүргэхэд 250 мянган төгрөг гэх мэтчилэн иргэдийн амьдрал бол хүнд байна. Яг энэ үнийн өсөлтийн үед иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр ер нь цаашидаа ямар арга хэмжээ авагдах вэ. Тухайлбал, цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэгдэх үү гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь бол нэг хэсэг бүлэг хүмүүс Их Хурал дээр заавал хэлж өгөөч гэж надад хүсэлт гаргасан. Энэ 50- 62 насны хооронд хүмүүс. Эд нар бол ерөөсөө гал алдлаа, ямар ч орлогогүй боллоо гэсэн хэсэг бүлэг хүмүүс байгаа юм байна ер нь улсын хэмжээнд. Ажил хийе гэвэл ажилд авахгүй, тэтгэвэр байхгүй, хүүхдүүд нь том болсон хүүхдийн мөнгө авч чадахгүй, ямар ч орлого байхгүй, одоо ер нь амьдрал хүндэрлээ гэсэн хэсэг бүлэг хүмүүс манай улсад байна. Ер нь энэ хүмүүсийн төлөө, төрөөс, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас ямар арга хэмжээ бодож байгаа юм бол? Ер нь төлөвлөж байгаа юм байна уу? Үнэндээ бол хэцүү шүү дээ. Ажил хийе гэвэл ажил олдохгүй, тэтгэврийн нас нь хүрээгүй, ямар ч орлогогүй байгаа хүмүүс хэсэг бүлэг хүмүүс байдаг юм байна. Энэ дээр бас нэг тодорхой хариу өгөх боломж байна уу гэж.

Хоёр дахь нь бол Оюу толгой. Яг өнөөдрийн байдлаар Оюу толгойн нь оруулж байгаа орлого болбол манай Эрдэнэтийн үйлдвэрийг гүйцэхгүй байгаа л даа. Тэгэхээр ирэх жил ер нь Оюу толгойн гүний уурхай хэдэн сард ашиглалтад орох юм бэ? Ашиглалтад ороод бидний орлого хэр нэмэгдэх юм бэ? Ер нь Оюу толгой бол баялаг нь манай Монгол Улсынх, тэгээдд өөрсдөө экспортод гаргаж байгаа. Орлого нь манайхаар дамжихгүй. Гэтэл Оюу толгойгийн дотор санхүү, эд засгийн асуудал бол манайхаас хувь эзэмшигчийн хувьд тодорхой хэмжээний хяналт тавих тийм боломж байгаа юм уу, ер нь хяналт тавьж байгаа юу? Цаашидаа орлого нь манайхаар дамжих уу, дамжихгүй юу?

*Ер нь Оюу толгой бол ирэх жилээс эхлээд хэр их хэмжээний ашиг өгөөд, манай манай төсвийн орлогыг хэр их хэмжээгээр нэмэгдүүлэх юм бэ? ард иргэдийн амьдралд хэр хэмжээний нөлөөлөх юм бэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.*

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд дөрвөн гишүүний асуулт хариултын дараа асуулт хариултын цаг дуусна. Тийм учраас 12.20-д чуулганы танхимд үүдэнд үзээд сууж байгаа болон танхимдаа үзэж сууж байгаа гишүүд орж ирээрэй. 12.30-аас Засгийн газрын гишүүнийг танилцуулах Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно. Хариулахын өмнө зочид танилцуулъя.

*Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын 10 жилийн сургуулийн 1980 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт төгсөгчид та бүхэндээ төрөлх нутаг, унаган сургууль, хайрт багш нараа эргэн дурсан санаж, гэгээн дурсамж дүүрэн өнөөдрийг өнгөрүүлэхийг хүсэн ерөөе өө. Та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе.*

*Сангийн сайд Болдын Жавхлан хариулна. Баделхан гишүүний асуусан асуулт. Оюу толгой ямар өгөөж өгөх вэ.*

**Б.Жавхлан:** Эхлээд тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай холбоотой асуултад хариулъя. Бид ямар ч байсан ирэх жил төсвийн орлого, зардал, бүх юмаа төсөвлөж тооцоолоод Хөдөлмөрийн хамгааллын яаман дээрээс хэрэгжүүлдэг бүх төрлийн хуулиар заагдсан халамжуудыг бүрэн санхүүжүүлж байгаа. Энэ дотор бүр өсөлттэй ч гарч байгаа. Ирэх жилүүдийн механик өсөлтүүд нэлээн гарч байгаа. Энийг бүрэн санхүүжүүлэхээр ингээд төлөвлөсөн байгаа. Тийм учраас хуулиар олгогдох ёстой, ажилгүйдэл, бусад халамжийн чиглэлийн бүх үйлчилгээ бүрэн санхүүжигдээд явах юм байгаа юм. Таны

*яг хэлж байгаа тэр ажилгүй, тэгээд тэтгэвэрт гарах нас нь болоогүй, тэтгэврээр тогтоогдоогүй, амжаагүй байгаа ийм хэсэг ард иргэд халамжийн чиглэлийн энэ хууль заалтуудад алинд нь хамрагдаж болохоор байна вэ, тэрэн дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бас тодорхой чиглэлээс хариу авах хэрэгтэй. Одоо төсвийн зүгээс энийг бол шууд хариулах боломж бол алга байна.*

*Оюу толгойн хувьд та Эрдэнэтэд арай хүрэхгүй л гэж байна. Яах вэ, энэ хоёрыг одоо өрсөлдүүлж ярих юм бол одоо бас учир дутагдалтай. Оюу толгойн яг жинхэнэ далд уурхайн, өөрөөр хэлбэл нийт баялгийнхаа яг 80 хувийг нь олборлож эхлэх гүний уурхайн ажил ирэх оны 6 сараас эхэлнэ. Ингээд хамгийн өндөр өгөөжтэй жилүүд нь 2028 оноос эхлэх юм байгаа юм. 2028, 2029, 2030 он гээд. Ирэх жилээс ямар ч байсан гүний уурхайн олборлолт бага хэмжээгээр эхэлж эхэлнэ. Энэний 100 гаруй 160, 170 тэрбум төгрөгийн нэмэлт орлого бол ирэх жил орж ирнэ. Яг тэр далдуур уурхайн эхний жилүүдэд нь. Ингээд цаашидаа 2-3 дахин хүртэл нэмэгдэх, ийм оргил үедээ очих ийм эргэлтгүй буцалтгүй ийм шатандаа орсон гэсэн үг. Энэ бол одоо яг Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед Оюу толгой дээр хийгдсэн, урагшаагаа хөгжил нь маш тодорхой болсон ийм сайн зүйл сайн алхам болсон гэдгийг хэлье.*

**Г.Занданшатар:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулххар.

**С.Зулххар:** Баделхан гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн насны, тэгэхдээ бас тэтгэвэрт гарч чадаагүй ялангуяа 50-60 насны ийм улсууд байгаа. Нэг талаар тэтгэврээ тогтоолгож чаддаггүй. Яагаад гэвэл нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь хүрдэггүй. Нөгөө талаар бас ажилд авдаггүй гэсэн ийм бэрхшээлүүд байгаа юм. Энэнтэй холбоотойгоор бол хоёр шийдэл, өнгөрсөн хугацаанд янз бүрийн хийж ирсэн. Энэ бол үргэлжилнэ. Эхнийх

нь бол хөдөлмөр эрлэлтийг дэмжих сангийн хүрээнд хэрэгжиж байгаа 7 хөтөлбөр, 28 арга хэмжээний нэг нь тухайн сангийн хөтөлбөр байгаа. Ахмад настны хөдөлмөр, эрлэлтийг дэмжих хөтөлбөр байгаа. Энийг бол бид энэ жил бас ахиад өргөжүүлж байгаа юм. Яг саяынхтай холбоотой жишээ нь хөдөлмөр хийе гэсэн боловч ажилд авдаггүй, ажил хийе гэсэн боловч орлоготой болж чаддаггүй иргэд рүү чиглэсэн байдлыг энийг зохицуулна гээд, журамд нь бас өөрчлөлт оруулж байгаа. Журам нь бол урьд нь эдгээр улсуудыг бол 2 сар хүртэл 3 сар хүртэл ийм зөвлөх үйлчилгээ ч юм уу, туслах ажил хийлгэдэг байсан бол энийг бид бол хугацааг нь аль болох урт байхаар ингэж зохицуулахаар журмыг нь өөрчилж байна.

Хоёр дахь зүйл бол эдгээр улсууд бол халамжийн тэтгэвэр авах эрх нь бол нээлттэй. Гэхдээ энэ бол бас насны хязгаартай учраас энэ чиглэлээр бол энэ нь үргэлжилнэ гэсэн ийм бодолтой байна.

Гурав дахь бас зүйл байгаа бусад хөтөлбөрүүд байгаа. Манай хөдөлмөрлөлтийг дэмжих 7 хөтөлбөр дотор эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр байна. Тэрнээс бол ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүд байна. Энэнд мөн адил эдгээр иргэдийг түлхүү, бас хүсэлтийнх нь дагуу оролцуулж ажилтай орлоготой болгох энэ чиглэлийг барина гэж бодож байгаа. Энэ жил үндсэндээ манай хөтөлбөрөөр бол 90.4 тэрбум төгрөг батлагдсан. Энд бол бидний тооцооллоор 63000 хүнийг ажлын байртай болгох, ажлын байрыг хадгалах ийм тооцоолол хийсэн байгаа.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар сайд нэмж хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Яг Монгол банканд тушаасан энэ Оюу толгойн орлого хэд вэ, Эрдэнэт үйлдвэрийнх нь хэд юм бэ гэдэг ийм асуулт байсан. Тэгээд Монголбанканд одоо яг орж ирээд орж

ирсэн гадаад валютын гүйлгээ нь болохоор 2021 оны байдлаар Оюу толгойгоос 1 тэрбум 728 саядоллар орж ирсэн. Эрдэнэт үйлдвэрээс 1 тэрбум 122 сая доллар орж ирсэн. 2022 оны 8 дугаар сарын байдлаар Оюу толгойгоос 1 тэрбум 24 сая доллар, Эрдэнэт үйлдвэр дээр 773 сая доллар орж ирж байна.

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Салдагийн Одонтуяа асуулт асууж, үг хэлнэ.

**С.Одонтуяа:** Тэгэхээр голчлон Хүрэлбаатар сайд, Сангийн сайд Жавхлан сайдаас асууя. Ер нь энэ бид нар эдийн засгаа ингээд нэг макро байна уу, микро байна уу, энийгээ бол иргэдийнхээ айл өрхийн бодит орлоготой л холбож сайхан ярьж баймаар байна. Талхтай нь, махтай нь, бензиний үнэтэй нь. Нөгөөтээгүүр, үндэсний аюулгүй байдалтайгаа бас холбож нэлээд ярьж ажилламаар байна. Та нар санаж байгаа байх. Саяхан Үндэсний аюулгүй байдлын тайланг бид нар сонссон. Ямар, ямар салбарт үндэсний аюулгүй байдлын энэ зорилтуудаа хангаж байна гэхэд 99 хувь нь хангалтгүй л гэсэн дүгнэлт гарсан. Энэ өөрөө маш ноцтой асуудал. Ялангуяа хүнсний аюулгүй байдал байна. Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ голчилж бас дүгнэж ажиллаа аа. Сая бас манай Пүрэвдорж гишүүн хэлж байна шүү дээ, нэг мөрийн хөтөлбөр шиг л юм уншаад байх юм гээд. Одоо дандаа ирээдүй цаг дээр өснө, хөгжинө, сайхан болно гэдгээ чухам больчихмоор байна.

Сүүлийн 15 жилд төсвийн бодлого, төсвийн тэнцэлд хийсэн дүгнэлт, санал маш зөв л гарсан байна. Аудитын дүгнэлт гарсан. Энэ зөвлөмжүүд гараад л байдаг, гараад л байдаг. Тэгээд яг улс төрийн шийдвэр дээрээ дандаа эсрэг гардаг. Одоо би бол ялангуяа Хүрэлбаатар сайдыг бүр онцгой сайн ажил гээж хэлмээр байна. Энэ МАН-ын 60, 65 хүн байгаа хэдий ч та бол гол хариуцлага үүрэх ёстой хүн шүү. Би 2012-2016 онд байхад Төсвийн байнгын хороо, сангийн бүх л ажлыг та хариуцаад



л явдаг л байсан. МАН-аас эдийн засаг, төсөв дээр гэхэд талд орж байсан.

Өмнөх дөрвөн жилд Сангийн сайдыг нь ч та хийлээ. Сангийн сайд хийхгүй үедээ Төсвийн байнгын хорооны даргын ч хийлээ. Жавхлан сайд ч гэсэн Монголбанк гээд л, ерөөсөө та 2 энэ гол, гол юмыг л хариуцаад л хийж байсан хүмүүс шүү. Тэгээд өнөөдөр ийм цоо шинэ юм яриад энэ нь болохгүй байна гэдэг юмыг бол нэг их хүлээж авмааргүй байна. Танайд тэр 60, 65 чинь юмаа уншдаг ч үгүй юм, та нарт найдаад л хаядаг юм. Тэгээд л ерөөсөө асуулт асуухаар хоёр, гурван хүн л хариулж байдаг шүү дээ. Ерөөсөө Монгол Улсын сүүлийн одоо эдийн засгийн асуудал, санхүүгийн асуудал, энэ бүх юмыг гол хариуцаж үүрэх хүн бол би бол Хүрэлбаатар сайдыг, Жавхлан сайдыг л гэж хардаг. Энэн дээрээ одоо та нар сайн ажиллаач ээ. Та нарт бол мэдлэг боловсрол, туршилага бол хангалттай л байгаа.

Дээрээс нь энэ төсөв их олон данстай байна гээд хамгийн их шүүмжилдэг байсан хүн бол манай Хүрэлбаатар сайд байгаа. Одоо энийгээ та нэг маш хурдан, энэ Сангийн яамтайгаа янзлаад цэгцэлмээр байна. Одоо бараг 10 гаруй л данстай болчихлоо. Тэр ч төрийн өмчит компани нь дуртай мөнгөө Их Хурлаар оруулахгүй зарцуулж л байдаг, иймэрхүү замбараагүй юмаа хурдхан, урьд нь шүүмжилж байсан зүйлүүдээ ажил болго оо. Одоо ингээд энэ бүх зүйлүүдийг хараад байхад 2023 онд ийм хэмжээний зарлагатай үед бид нарын энэ валютын нөөц хүрэхгүй. Тийм учраас одоо маш аюултай нөхцөл байдал үүсэж байна.

Эдийн засаг сайжрах уу, муужрах уу, ерөөсөө хувийн хэвшилээс л хамаарна. Одоо би хувийн хэвшилээ сайн дэмжээд өгөөч ээ л гэж хэлмээр байна. Саяхан төсвийн хэлэлцүүлэг хийсэн. Төсвийн хэлэлцүүлэг дээр хувийн хэвшил бүр үгээ хэлж байна шүү дээ, төрийг бүр үзэн ядах хэмжээнд оччихсон байна. Жишээлэхэд,

төсөв батлагддаг нэг тендер авдаг, Сангийн яам гэнэт тас гээд л нөгөө Төсвийн хууль болчихсон юмыг нь дараа жил өөрчлөөд л дахиад л хасаад ороод ирж байна, бид нар чинь юмаа төлөвлөчихсөн байгаа шүү дээ, тэгээд дампуурлаа гээд аж ахуйн нэгжүүд бүр аргаа барчихсан байна шүү дээ. Тэгэхээр ингэж хувийн хэвшилээ нугасалдаг аа боль оо.

Нэг үйлдвэр хувийн хэвшил аваад л ажиллуулж байна, алдагдалтай үедээ нөгөө салбараасаа нөхөөд ажиллаж байна. Төр очоод булаагаад л авна. Тэгээд тэрийгээ хэдэн дарга нар очоод л, бүх телевизээр гаргаад. Энэ чинь гадаадын хөрөнгө оруулагчид бүх бизнес эрхлэгчдийг нугасалж байна, хөрөнгө оруулалт чинь нэмэгдэхгүй шүү дээ. Тийм учраас энэ гол зүйл дээрээ ажиллаач ээ. Тариаланчид, энэ хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид махны.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Одонтуяа гишүүний хэлж байгаа зүйлүүдтэй би шүүмжлэлтэй зүйлүүдийг нь ч бас хүлээж авч байна. Зарим зүйлийг ирээдүй цаг дээр яриад байна гэж хэлэх юм. 2023 онд авч хэрэгжүүлэх бодлого гээд гэхээр чинь одоо 2023 гэдэг чинь болоогүй байгаа шүү дээ, одоо гарахад гурван сар дутуу байна. Тэгээд 2023 онд авч хэрэгжүүлэх бодлогыг би ирээдүй цаг дээр ярихаас өөр аргагүй. Одоо би 2023 хоног өнгөрсөн цаг дээр ярьж арай л болохгүй юм байна.

Олон төсөвтэй гэж байгаа. Энэ дээр ийм ийм байгаа, яг төсөв бол төсөв дээр байх ёстой, бүх зүйл нь байгаа. Харин аж ахуйн нэгжийн ашиг, орлогыг бид нар авч ирж энэ төсөвтэй хольж болохгүй. Компаниудын орлого тусдаа, тэр хуулиараа тайлагнаад хувьцаа эзэмшигчдийнхээ шийдвэрээр зарцуулагдаад ингээд явагдах учиртай. Энэ дээрээс хэрвээ Их Хурал тэрийг нь

мэдээд эхлэх юм бол Их Хурал өөрөө хууль зөрчсөн үйл ажиллагаа руу болчихно гэдгийг би хэлье. Хувийн хэвилийг дэмжих ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа.

Зүгээр, нэг л зүйл би бас хэлье. Ингээд 2012 оноос хойших бүх юмыг надтай холбоод хэлчих шиг боллоо. Би энд гарын үсэг зурдаг. Яг өөрөө гаргаж шийдвэр гаргадаг ийм зүйл дээрээ хариуцлага хүлээнэ. Сангийн сайд байхад Монгол Улсын эдийн засаг 6.3 хувиар өссөн. Ажил авч байхад валютын нөөц 1.7 тэрбум америк доллар байсан юм. Ажил өгч байхад 5 тэрбум доллар болсон. Арилжааны банкнуудаас нийтдээ 9.3 их наяд төгрөгийн өр төлж дуусгасан. Урьд өмнө нь бий болгочихсон байсан 2.3 их наяд төгрөгийн концессын өр ирсэн. Үүнээс энэ жилдээ 220, 230 тэрбум төгрөг л үлдэж байгаа байх. Үндсэндээ 2 их наяд төгрөгийн өр бас дараад дууссан. Тэгэхээр би юу гэж хэлэх вэ гэхээр өөрөө яг энд гараараа шийдвэр гаргадаг тэр зүйлүүд дээрээ би бол хариуцлагаа хүлээгээд явна аа.

Ер нь ч болохгүй байгаа зүйлийг зөв болгоё, буруу зүйлд цаашаа даамжирч болохгүй гэдэг ийм байр суурьтайгаар хандаж ажлаа хийж ирсэн. Би бол энэ зарчмыг хатуу баримталж ажиллана. Ямар нэгэн буруу зүйлийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй, буруу зүйлийг засахын төлөө өөрөөсөө хамаарах бүх зүйлээ хийнэ. Тэгээд энэ дээрээс эдийн засгийн бодлогыг авч хэрэгжүүлээд, ирэх жилдээ эдийн засгаа тогтворжуулаад, инфляцын түвшин нэг оронтой тоотой болгохын төлөө бүх зүйлээ хамаарна. Гэхдээ эдийн засгийн олон бодлогууд чинь олон уялдаатай явдаг учраас өөр газар гараад байгаа алдаа бас байдаг. Тэр алдааг ч гэсэн засахын төлөө болгож чармайж, хичээж болж ажиллана л гэдгийг хэлье. Хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна аа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Дуламдоржийн

Тогтохсүрэн, Содномын Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн нэрийн өмнөөс эрхэм хүндэт Арвайхээрчүүд та бүхэндээ, багш, ажилчид та бүхэндээ ардын хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх их үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн нэрээ татсан. Хоёр гишүүний асуулт, хариултын дараа асуулт, хариултын цаг дуусна. Засгийн газрын гишүүнийг танилцуулах Ерөнхий сайдын мэдээллийг сонсох тул гишүүд чуулганы танхимд цуглана шүү. Одоо Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Боомтын сэргэлтийн талаар бас хоёр, гурван асуулт байж байна. Бямбацогт сайдаас асууя. Ялангуяа энэ боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр санал нэг байж байгаа. Одоо хамгийн гол асуудал бол бид нар экспортоо сайн хийх хэрэгтэй байна, импортоор орж ирж байгаа ачаагаа бас хурдан хугацаанд татаж авах хэрэгтэй байж байна. Тээврийн үнэ бас өндөр байгаа учир бараа таваарын үнэ бас нэмэгдээд байж байна. Одоо боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг хамгийн их хурдан хугацаанд сайжруулах асуудал бол би төмөр замын асуудал аа гэж харж байгаа. Тийм учраас одоо юу гэдэг юм Сүхбаатар аймгийн Бичигтэд цаана байгаа Хатавчаас Бичигт рүү нарийн царигийн төмөр замыг 5-аас 10 километр оруулж ирэх, мөн Шивээхүрэн боомтын цаана байж байгаа Сэхээ боомт дээр байж байгаа нарийн цагаригийн төмөр замыг Шивээхүрэн боомт руу 5-аас 10 километр оруулж ирэх, бусад Ховд байна уу, Баян-Өлгийд байж байгаа одоо цаад талын боомтод байж байгаа нарийн царигийг Монгол Улсын хил рүү 5-аас 10 километр оруулж

*ирж байж экспорт сайжрах юм байна аа. Ингэж харж байгаа.*

*Энэ малын болон хүний гоц халдварт өвчин цаашидаа олон гарч магадгүй. Тийм учраас бид нар ухаалаг тээврээ бас үргэлжлүүлэхийн тулд энэ төмөр замынхаа гарцуудыг их зөв тодорхойлж, нарийн царигийн төмөр замыг л яаралтай оруулж ирэх шаардлагатай байна л гэж би үзэж байгаа юм. Энэ бол боомтын хүчин чадал, нэвтрүүлэх хүчин чадлыг бол хоёр дахин нэмнэ шүү. Энэ дээр та хэд дорвитой арга хэмжээ аваад аваадхаач.*

*2019 онд Замын-Үүд боомтод нарийн царигийн төмөр зам байхгүй байсан. Бүс нутгийн ложистикийн төв гэж Азийн хөгжлийн банкаар хоёр нарийн цариг цариг оруулж ирсэн. Энэ бол энэ сая КОВИД-ын энэ хоёр, гурван жилийн хугацаанд импортын бараа эргэлтийг таслаагүй шүү. Маш хурдан хугацаанд орж ирсэн. Энэний үр дүнг үр ашгийг бид сая энэ хоёр, гурван жилийн хугацаанд бас хүртсэн. Тийм учраас бид ухаалаг тээвэр буюу цаана байж байгаа нарийн царигийг Монгол Улсын хил рүү 5-10 километр оруулж ирэх асуудлаа бас яаралтай шийдэх хэрэгтэй. Би бол Сайнишанд, Сүхбаатар, Бичигт, Хөт ч гэдэг юм уу, энэ төмөр зам бол нэлээн хугацаа шаардах болов уу гэж бодож байна. Шивээхүрэнгээс Арцсуурьт хүртэл 1200 километр төмөр замын асуудал бол мөддөө шийдэгдэхгүй дээ. Амьдрал өөрөө баялан баян. Бараг шийдэгдэхгүй. Хамгийн хурдан хугацаанд бид нар энэ хүчин чадлаа нэмэгдүүлэх, орж гарах асуудлаа шийдэх гарц бол ерөөсөө л нарийн цариг байж байгаа юм. Энэ дээр нэг хариулт хэлж өгөөч гээд.*

*Хоёр дахь асуудал дээр босоо тэнхлэгийн хувь нийлүүлсэн төмөр замыг хос болгох асуудал дээр ер нь ямар бодлого барьж байгаа юм? Техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн зүйл байдаг юм уу? Энийг хос болгохгүй бол энэ тээврийн үнэ чинь дийлдэхээ болилоо. Хэрвээ энийг хос*

*болгож чаддаггүй бол нөгөө Н-3 гэдэг хурдны авто замаа яаралтай барьж эхлүүлээч ээ. Маш богино хугацаанд зам тавих бололцоо боломж байж байна. Дорноговь аймгийн бүс нутаг дээр өнөөдөр 4-5 босоо тэнхлэгийн авто замыг тавьсан асфальтны үйлдвэрүүд нь хайрга, дайрга нь яг бэлэн байж байна. Энийг яаралтай эхлүүлэх юм бол I жилийн хугацаанд Налайх хүртэл хатуу хучилттай хүнд даацын энэ авто замыг тавих ийм бололцоо, боломж бол байгаад байна гэдгийг хэлмээр байна.*

*Гурав дахь асуудал бол энэ боомтуудаа та хэд олон улсын боомт болох тал дээр анхаараач ээ. Баяннуур аймгийн Гашиунсухайт чинь бол үндсэндээ Баяннуур цаад талдаа хариуцдаг шүү дээ. Ханги-Мандал боомт байж байна. Бугат баг хариуцдаг. Тэгээд импортын ачаа орж ирэхгүй байна. Тийм учраас энийг олон улсын болгож байж экспорт нь ч гардаг, импортын ч ордог ингэж байх юм бол нөгөө үнийн өсөлт, тээвэр гэдэг асуудал чинь бол зохицуулагдах ийм бололцоо, боломж байна. Тийм учраас энэ дээр одоо бас нэг анхаараач ээ. Боомт дээр эрчим хүчний асуудал, усны асуудал их хүнд байж байгаа юм. Энийг хүн болгон мэдэж байгаа.*

**Г.Занданшатар:** Асуулт, үг нэг явж байгаа. Үндсэндээ үг хэлчихлээ. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт харуулна.

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн бас чухал асуудал бол хөндлөө. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлаас баталсан шинэ сэргэлтийн бодлого хөтөлбөрт нийтдээ боомтын сэргэлтийн зорилтууд тусгагдсан байгаа. Үүнд зам, тээврийн салбартай холбоотой нийт 42 төсөл байгаа. Төмөр замын 9 төсөл, авто замын 17 төсөл, агаарын хилийн боомтуудыг нэмэгдүүлэх 8 төсөл, хилийн боомтуудын хүчин чадлыг сайжруулах, терминал байгуулах 9 төсөл гээд. Энэ дундаа бас онцгой анхаарч байгаа төслүүд бол бид



төмөр замын төслүүдийг ажиллуулахад анхаарч байгаа.

Таны хэлж байгаа нарийн царигийн асуудлыг бид Замын-Үүд дээр бол хийгдсэн. Замын-Үүдэд бол үндсэндээ бол өргөн нарийн царигийн терминалууд байгуулагдсан. Хятадаас орж ирж байгаа ачаа бол нарийн цариг дээрээ орж ирээд буудаг, Монголоос гарч байгаа ачаа бол өргөн цариг дээрээ Хятад руу орж буудаг. Яг ийм байдлаар хил гарч байгаа төмөр замууд дээрээ бас яг ийм байдлаар өргөн, нарийн царигийн терминал байгуулах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

Гашуунсухайтын төмөр зам баригдсан 240 километр. Энэ төмөр зам бол бас яг энэ өргөн нарийн царигийн терминалыг барьж байгуулахад одоо зураг төсөл хийгдэж байна. Ханги-Мандалын төмөр зам дээр бас өргөн, нарийн царигийн терминалын ажил хийгдэж байгаа. Таны ярьж байгаа зүүн босоо тэнхлэгийн төмөр зам, хойноосоо Эрэнцав, Чойбалсан, Хөөт, Бичигт ирсэн энэ чиглэлд төмөр замын маршрут гарч байгаа. Чойбалсан, Хөөт, Бичигтийн чиглэлийн төмөр зам дээр бол концессын шалгаруулалт явагдаж байгаа. Энэ чиглэлд бас ингээд барихдаа өөрийн чинь хэлж байгаагаар өргөн, нарийн царигийн терминалыг хамтад нь байгуулах ийм байдлаар бас гэрээ хийгдэх ёстой болов уу гэж бодож байна.

Шивээхүрэн чиглэлд өргөн, нарийн царигийн энэ терминал байгуулах ажил хоёр тусдаа компани бас яригдаж байгаа. Үүнийг бас нэгтгэж бодлогоо нэгтгэх энэ ажил бол хийгдэнэ. Ер нь бол ингэж байж үндсэндээ бол бид экспортын ачаагаа ихээхэн хэмжээгээр гаргах, шинэ сэргэлтийн бодлогын боомтын сэргээлтийн зорилтууд хэрэгжих юм. УБТЗ-ыг хос болгох асуудал бол олон жил яригдаж байгаа. Ер нь бол үе шаттайгаар хүчин чадлыг нь яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр бид анхаарч ажиллаж байна. УБТЗ бол зөвхөн Монголын өмчийн биш, Орос, Монголын

хамтарсан 50, 50 хувь эзэмшигч компани. Тийм болохоор Оросын талтай энийг хос болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар ажлууд гэрээ хэлцэл хийгдэж тодорхой ажлууд явагдаж байна. Богдхаан төмөр зам, дээрээс нь Зүүнбаян, Сайнишандын төмөр замыг шинэчлэх, Замын-Үүдэд тодорхой хэмжээний төмөр замын хүчин чадлыг өргөтгөх ийм ажлууд үе шаттай явж байгаа. Ер нь цаашидаа бол ОХУ-тай, Оросын төмөр зам компанитай бас ярилцаад энэ УБТЗ-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг нэлээн эрчимтэй хийж хэрэгжүүлнэ гэж бодож байгаа.

Босоо хурдны зам үндсэндээ бол 2011 онд Чингис Лэнд гэж компани концессын гэрээ Алтанбулаг, Улаанбаатар Замын-Үүд чиглэлийн хурдны замыг концессоор барина гээд авсан байдаг боловч одоог болтол ажил хийгдээгүй. Гэрээг нь цуцлаад ажлыг нь эхлүүлэх гэхээр шүүхдээд гацаачихдаг ийм байдалтай явж байгаа юм байна лээ. Гэхдээ одоо ингэлээ гээд хойшоо суухгүй байгаа. Улаанбаатар, Дарханы дөрвөн эгнээ, хоёр урсгалтай замыг үргэлжлүүлж Дарханаас цааш Алтанбулаг чиглэлд дөрвөн эгнээ, хоёр урсгалтай болгох, мөн Налайхаас Сайнишанд, Замын-Үүдийн чиглэлд дөрвөн эгнээ хоёр урсгалтай болох ажил дээр бас Зам, тээврийн хөгжлийн Монгол Улсын Засгийн газар анхаарч ажиллаж байгаа. Үндсэндээ бол энэ нээлттэй. Энд хөрөнгө оруулаад концессын болон бусад хэлбэрээр хөрөнгө оруулаад ажиллах компаниуд, гадна, дотнын байгууллагууд байх юм бол бид нар хамтарч ажиллахад бэлэн байгаа. Өөрөөр хэлэх юм бол энийг маш богино хугацаанд хийж хэрэгжүүлэх ёстой. Ингэж байж Ази, Европыг холбосон, мөн Орос, Хятадыг холбосон хурдны авто замтай болно. Ингэж байж бас ачаа тээврийн эргэлт бараа нэмэгдэнэ. Ачаа тээврийн эргэлт. Тийм болохоор бас онцгой анхаарч энэ замыг хурдан барьж байгуулах тал дээр санхүүжилт, одоо санхүүжилт хийж гүйцэтгэх компаниудыг бас хайж эрэлт хийж ажиллаж байгаа гэдгээ бас хэлье.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Булган багштай Гар бөмбөгийн клубийн өсвөрийн шигшээ багийн хамт олон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ гишүүдийн нэрийн өмнөөс спортын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Нанзадын Наранбаатар гишүүн.

**Н.Наранбаатар:** Баярлалаа. Боомт дээрээ бид илүү сайн, 2023 онд бол анхаарч ажиллах ёстой. Валютынхаа нөөцийг нэмэгдүүлэх ёстой, үнийнхээ өсөлт, инфляцаа бид барих ёстой гээд. Энэ бүх ажлуудыг ярихаар боомтын хөгжилтэй холбоотой нэвтрүүлэг, чадвартай холбоотой л асуудал яригддаг юм. Энэ Хөгжлийн хөтчөөс зураг төсвийг боловсруулаад эхлүүлсэн Гашуунсухайтын боомтын бүтээн байгуулалтын ажил бас гурван жил ингээд гацчихлаа. Тэгээд боомтын маань нөхцөл байдал одоо бас маш хүнд байна, уух уснаас өгсүүлээд тэнд амьдрах орчин, лабораториос өгсүүлээд ингээд асуудал их байна гэдгийг сая төсөвтэй хамт олон нийтийн хэлэлцүүлэг хийхэд боомтын сэргэлт дээр бол маш олон ТББ, иргэдийн төлөөлөл бас ярьж байсан юм.

Тэгээд 2023 онд энэ ажил цаашаага яаж үргэлжлүүлэхээр та бүхэн төлөвлөж тооцож байна. Гаднын, БНХАУ-ын компаниас энэ ажлыг хийх ийм ажил нь анх эхэлж байсан. Энэ цаашаа яаж үргэлжлэх юм гэдэг дээр нэг тодруулга авчихъя. Ер нь Хөгжлийн хөтөч энэ төслийн баг цаашидаа Сангийн яам дээр явж байна уу, Эдийн засаг хөгжлийн яам руу ингээд харьяалагдаад явж байна уу гэдэг дээр нэг тодруулъя.

Валютын нөөц маань өнөөдрийн байдлаар ямар хэмжээнд оччихов. Ирэх жил ер нь хэрхэн яаж нэмэгдүүлэх баримжаа тооцоо байна вэ? Экспортыг бол 36.5 сая тонноор ингээд нүүрсний экспортыг бас төлөвлөөд явж байгаа.

Энэ 36.5-аас чинь хэдий хэмжээ нь off-take гэрээгээр хийчихсэн нүүрс гарах юм бол? Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохицуулалт хийгээд одоо шууд төлбөр нь орж ирж байхаар энэ борлуулалт экспортыг хийхээр зохицуулалт хийж байгаа юу? Хийж байгаа бол хэдэн хувь нь шууд орлого нь орж ирж байхаар манай төсөвт валютын нөөц болж орж байхаар тооцож байгаа гэдэг нэг ийм асуудал байна.

Дараагийн дугаарт энэ Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооныхон бас үйлдвэрлэл эрхлэгч нартайгаа уулзаж байхад нэг зүйлийг их ярьж байгаа. Тэр нь боловсруулалтын түвшинд авдаг энэ АМНАТ-ыг эргэж хараач ээ гэдэг асуудал яригдаж байгаа. Тийм учраас энэ дээр та бүхэн цаашидаа яаж тооцъё гэж бодож байна вэ? Энэ АМНАТ-ыг үйлдвэрлэлийн шатанд ногдуулдгийг зөв гэж үзэж байгаа юу, буруу гэж үзэж байгаа юу гэдэг дээр бас нэг тодруулга явъя гэсэн ийм гурван төрлийн асуулт байна.

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Гашуунсухайт боомтын шинэчлэлийн ажил яг хэзээ эхлэх вэ гэж байгаа. Тэгэхээр Азийн хөгжлийн банкны зээлээр Алтанбулаг, Бичигт, Боршоо гэсэн гурван боомтын шинэчлэлийн ажил хийгдэж байгаа юм. Үүнээс Алтанбулаг, Боршоо хоёрын боомтын шинэчлэл нэлээд явчихсан. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Замын-Үүдийн боомтын шинэчлэл, Гашуунсухатын боомтын шинэчлэл хоёр хийгдэж байгаа юм. Тэгээд энэ Замын-Үүдийн боомтын шинэчлэл, Гашуунсухайтын боомтын шинэчлэлийг хийж байгаа нь аж ахуйн нэгж нь нэг юм байгаа юм. Тэгээд БНХАУ-аас явуулж байгаа нөгөө “Тэг КОВИД” бодлогынхоо хүрээнд урд хилээс наашаа ажилчин орж ирэхэд их төвөгтэй компанийн хүмүүсүүд нь орж ирэх төвөгтэй байгаа хэдий ч

гэсэн Замын-Үүдийн боомтын шинэчлэлийн ажил хийгдээд нэлээд дуусах шат руугаа орж байгаа. Уг нь анх гэрээгээрээ бол энэ оны 10 сард орохоор гэрээ хийгдэж байсан санагдаж байгаа. Дуусангуутаа Гашуунсухайтаар орно гэдэг ийм зүйл яригдсан гэж би ойлгосон, урьд нь. Эхлүүлээд явж байгаад тэндээрээс эхний шатны ажлыг хийсэн компани нь Гашуунсухайт дээр очиж ажиллана гэдэг төлөвлөгөөтэй байж байгаад энэ хил хоригтой холбоотойгоор явж чадахгүй болсон гэж ойлгосон. Гэхдээ бол энэ ирэх жилдээ Гашуунсухайтын боомтын бүх бүтээн байгуулалтын ажлууд бол эхэлчихнэ гэж ойлгож байгаа гэдгийг хэлье.

Валютын нөөц яг хэд болсон юм бэ гэж байгаа юм. 8 сарын дүнгээр бол валютын нөөц 2.6 тэрбум америк доллар байсан. 9 сарын дүнгээр энэ 2.6 тэрбум доллар өсөөд 2.8 тэрбум америк доллар болж өссөн байгаа юм. 2795 сая долларын валютын нөөц. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар бол хоёр шийдвэр гаргасан. Эхлээд Засгийн газрын тэмдэглэл гаргасан. Засгийн газрын тэмдэглэл анх гарахдаа бол off-take-ийн гэрээгээр нийлүүлэгдэж байгаа нүүрс, урьдчилгаа төлбөрийг нь авсан нүүрснүүдийн нүүрс гэрээгээр гарч байгаа нүүрсүүдийг зогсоогоод төлбөрөө өгөх, нүүрсийг тээвэрлэх гэдэг ийм агуулгаар гарсан. Дараа нь off-take дээр гарч байгаа нүүрс, урьдчилгаа төлбөрөөр гарч байгаа нүүрс, мөнгөөр төлөгдөж байгаа нүүрсүүдийг төлбөрийн тэнцлийг сайжруулахаар валютын урсгалыг нэмж байхаар зохицуулалттайгаар гарга гэдэг ингэж өөрчлөгдөж ингэж л ажиллаж байгаа. Тэгээд энэ бүгдээрээ зохицуулалт хийхээр түрүүн хэлж байгаа Эдийн засгийн яам, Сангийн яам, Уул уурхайн яам хамтарсан ажлын хэсэг гаргаад манай энэ дэд сайд ахалсан ийм ажлын хэсгийг н тогтоолын хэрэгжилт дээр ажиллана гэдгийг би хэлье. Тэгээд аа гарч байгаа үр дүн болгоныг бид нар танилцуулаад явна. Яг Засгийн газрын тогтоол гарснаас хойших

хугацаанд бол 260.6 сая америк доллар орж ирсэн байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** АМНАТ, Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя. АМНАТ-ыг боловсруулалтын шатнаасавч байх уу гэсэн.

**Ч.Хүрэлбаатар:** АМНАТ бол, энэ дээр бас нэг юм залруулаад хэлчихмээр байгаа юм. Хүрэлбаатар байхдаа АМНАТ-ыг ингээд бүгдийг нь яачихсан гэж. Сангийн сайд байхад АМНАТ тооцдог бол гэрээний үнээр авдаг байсан. Ажлаа өгснөөс хойш 7 сарын дараа буюу 2021 оны 8 сараас эхлээд энэ шинэчилсэн журмын дагуу АМНАТ тооцдог болсон юм байна лээ шүү гэдгийг би бас нэгдүгээрт нь хэлчихье.

Хоёрдугаарт нь бол энэ чиглэлээр Сангийн сайд, Уул уурхайн сайд бид гурав бол ярилцаж байгаа. Тэгж байгаад ярилцаж байгаа зүйлээ нэг ажил хэрэг болгоод та бүгдэд ирж мэдэгдье.

**Г.Занданшатар:** Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт нэмж хариулна.

**С.Бямбацогт:** Гашуунсухайтын боомтын нөхцөл байдал бол бас их амаргүй байгаа юм байна лээ. Сар гаруйн өмнө бас газар дээр нь очиж танилцсан. Үнэхээр тэнд их олон жил нүүрс тээвэр хийсэн. Монгол Улсын үндсэндээ экспортын нүүрсний гол орлого тэр бомтоор ордог, жилдээ 20 гаруй сая тонн нүүрс борлуулж орлого олдог. Тэнд үндсэндээ бол 20-иод мянган жолооч, ажил амьдралаа залгуулж тээвэр гэж амьдардаг. Гэсэн мөртөө тэр боомт дээр тог байхгүй, ус байхгүй, сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй, халуун ус, эмнэлэг байхгүй, тийм байдалтай нөхцөл байдалтай үйл ажиллагаа явуулж байгаа юм байна лээ.

Тийм болохоор одоо үндсэндээ бид зөвхөн одоо тээвэр хийх замаа засахаас гадна боомтын жолоочгүй AGV

нэвтрүүлэхээс гадна төмөр зам тавихаас гадна тэнд ажиллаж байгаа амьдарч байгаа тээвэрчдийн ажил амьдралынх нь нөхцөл байдлыг сайжруулах тал бас онцгой анхаарах ёстой юм байна лээ. Тэгээд суурьшлын бүс бий болгох. Ингэж байж тэнд байнгын, ганцхан жил, хоёрхон жил тээвэр хийхгүй шүү дээ. 10, 20 жил, 100 жил тэр боомтоор нүүрс тээвэрлэх байх. Тийм болохоор тэнд суурьшлын бүс болгох, нийгмийн дэд бүтцүүдийг нь шийдэж өгөх, энэ ажлуудыг бас яаралтай хийж хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ тал дээр бас Засгийн газар цаашидаа онцгой анхаарч ажиллах шаардлагатай юм байна лээ. Энийг бас хийж хэрэгжүүлэх ёстой гэж бодож байгаа. Тэгэхгүй бол өнөөдөр яг үнэндээ бол ерөөсөө хэдэн кэмптэй, ямар ч нийгмийн үйлчилгээ байхгүй ийм байдалд л тэр 20-иод мянган жолооч үйл ажиллагаа явуулж байгаа.

Замынх нь төлбөр хураамжийг Эрдэнэс Монгол компанийнхан цалингаа тавьчихдаг. Уул нь тэр зам засаад, тээвэрт явж байгаа тээвэрчдийн осолгүй аюулгүй нүүрсээ тээвэрлэх бололцоо, боломжийг хангахад тэр замын төлбөр хураамж орж байх ёстой. Гэтэл ихэнх төлбөр нь хураамж нь тэр Эрдэнэс Монгол компанийн ажилчдын цалин болчихдог. Иймэрхүү нэг тийм зүй бус гэдэг юм уу, энэ тогтолцоонуудыг жоохон анхаарах ёстой асуудлуудыг бид анхаарч цаашидаа ажиллах ёстой. Энэ тал дээр бас анхаарч ажиллана гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Асуулт, хариултын цаг дууслаа.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл цахимаар хуралдаж, хэлэлцэх асуудлын тов, дараалалд өөрчлөлт оруулж, өнөөдөр Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга, үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааг нэмэхээр хуваарьт өөрчлөлт оруулсан болохыг даргын Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн болохыг мэдэгдье.

**Одоо ингээд Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.** Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилно. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт Засгийн газрын гишүүний орон, гарсан тохиолдолд Ерөнхий сайд түүнийг энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан журмын дагуу 14 хоногийн дотор нөхөн томилно гэж заасныг тус тус үндэслэж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан тушаалд Төмөрбаатарын Аюурсайханыг томилуулахаар Улсын Их Хуралд танилцуулж байна.

Төмөрбаатарын Аюурсайхан 1975 онд төрсөн, 1993 онд нийслэлийн 23 дугаар дунд сургууль, 1999 онд БНТУ-ын Докуз Ейлүл их сургууль, 2006 онд Японы Олон Улсын их сургууль, Сөүлийн Үндэсний их сургууль, 2014 онд Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг,



бизнесийн сургуулийг тус тус төгссөн, эдийн засагч мэргэжилтэй. Олон улсын хөгжлийн эдийн засгийн магистр, боловсролын докторын зэрэгтэй, 2000-2005 онд Аста Пресс ХК-ийн ерөнхий захирал, 2006-2009 онд Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газарт ахлах рефрент, 2008-2012 онд Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, МАН-ын Хэрэг эрхлэх газарт улс төрийн ажилтан, Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх, 2012 онд Чингэлтэй дүүргийн Засаг дарга, 2013-2015 онд МАН-ын Хяналтын ерөнхий хорооны дэд дарга, 2015 онд Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2019- 2020 онд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2020 оноос Улсын Их Хурлын дэд даргаар тус тус ажиллаж байна.

Аюурсайхан нь улсад 22 жил ажилласан туршлагатай. Энэхүү туршлагыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан тушаалд Улсын Их Хурлын дэд дарга Төмөрбаатарын Аюурсайханыг тохирно гэж Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд үзэж байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Г.Занданшатар:** Эрхэм Ерөнхий сайдад баярлалаа. Ерөнхий сайд болон томилогдох Засгийн газрын гишүүнээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Балжиннямын Баярсайхан гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Аюурсайхан нэр дэвшигчийн тухайд бол энэ бас зөв томилгоо болсон байх аа гэж бодож байна. Зүгээр би үг хэлчихье. Өнөөдөр энэ нийгэмд хуримтлалдаа байгаа хамгийн том том асуудлууд бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяалах асуудлын хүрээнд үүсээд байгаа. Энэ дээр бол таныг бас тодорхой Засгийн

газрынхаа мөрийн хөтөлбөрт тусгагдсан, цаашилаад энэ улс орны эдийн засаг хүндэрсэн энэ цаг үед энэ ажлын байрыг бий болгох, нэн ялангуяа төрийн албан хаагчид, тэтгэврийн насны хүмүүсийн тэтгэвэр, цалин мөнгөний асуудал дээр тодорхой шийдэл гаргаж, энэ дээр зөв бодлоготой ийм шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай байна.

Нэн ялангуяа хөдөө орон нутагт эдийн засаг хүндрэлтэй холбогдож, ядуурал бий болсон, ажлын байр хомстсон, хөдөө орон нутагт бүр төрийн албан хаагчид цалин мөнгөний асуудлаас болоод ажиллах боломжгүй болсон зэрэг ийм нийгэмд үүссэн энэ онцгой асуудлыг Улсын Их Хуралтайгаа сайн зөвшилцөж бодлогын хэмжээнд зөв шийдвэрийг гаргаж явна гэдэгт би итгэлтэй байгаа. Ингээд танд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даицэгвийн Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Засгийн газрын Хэрэг эрлэх газрын ахлах референт Чулуунбаатарын Дондогмаа.

Одоо Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Аюурсайхан гишүүнийг төрийн албаны туршилага болоод мэдлэг боловсролын хувьд энэ салбарыг удирдаад авч явах ийм бас чадвартай хүн гэж дэмжиж байна. Тэгэхээр Аюурсайхан гишүүний хувьд бас Их Хуралд Байнгын хорооны дарга, дэд даргаар ажиллаж байхдаа олон хууль тогтоомжийг бас ахалж батлуулж байсан туршлагатай. Тэгэхээр одоо манай Их Хурал дээр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол удаан хугацаанд хүлээгдэж байгаа. Энэ Нийгмийн даатгалын багц хуулийг өргөн бариад, дараа нь дараагийн сайд нь ирэхээрээ буцаагаад татаад авчихдаг. Тэгээд ерөөсөө хэлэлцэж эхэлдэггүй нэг ийм хуультай болчихсон. Тэгэхээр хууль нь

батлагдаагүй учраас гүйцэтгэх засаглал ажлаа хийхэд бас их бэрхшээлүүд тулгараад байгаа. Тийм учраас энэ Нийгмийн даатгалын багц хуулийнхаа шинэчилсэн найруулгыг Их Хурлаар батлуулахад бас ажлаа эхлээсэй гэж хүсэж байна. Тэгээд бас кабинетын гишүүний хувиар Аюурсайхан гишүүнтэйгээ Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах болоод, миний хувьд бас гишүүдтэйгээ хамтарч Их Хурлын даргын захирамжаар байгуулагдаж ажилласан тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх энэ ажлын хэсгийн хүрээнд хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн бариад одоо ч бараг хоёр жил, гурван жилтэйгээ золгож байгаа. Тэгэхээр энэ хуулийг Нийгмийн даатгалын багц хуультайгаа хамтатгаад хуулиа батлуулах ажлаас ажлаа эхлээсэй гэж бас чин сэтгэлээсээ хүсэж байна.

Өнөөдрийн энэ тэтгэвэртээ гарсан тэтгэврийн сан бол цаашидаа явах ийм гарц, арга замгүй болсон. Ямар нэгэн байдлаар тодорхой хэдэн хувийг ч гэсэн хуримтлал шилжүүлэх энэ шинэчлэлийг бол бас салбар өөрөө хүлээлттэйгээр харж байгаа. Энэ эрдэм судлалын чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд бас энэ хууль руугаа илүү орж, хуулиа батлуулж, салбараа концепцоор нь харж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд Засгийн газрын гишүүний хувиар бас энэ хуулийг батлуулахад болоод салбарынх нь ажлыг дэмжихэд хамтарч ажиллахдаа их баяртай байна. Танд ажлын амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Одоо эрхэм гишүүн Бадарчийн Жаргалмаа. Түр байж байгаарай Жаргалмаа гишүүн.

Зочдоо эхлээд танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адышаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм Ховдчууд та бүхэндээ Улсын Их Хурлын

гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Баруун хязгаарын түмэндээ.

Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн үг хэлнэ.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Ерөнхий сайдаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад Улсын Их Хурлын дэд дарга Аюурсайханы нэрийг оруулж ирж байгаад бас талархлаа илэрхийлье. Гэхдээ Аюурсайхан дарга маань ер нь хүндхэн цаг мөчид гэх юм уу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилогдож байна. Яг үнэхээр сая Учрал гишүүний хэлсэнчлэн Нийгмийн даатгалын багц хууль болоод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль гээд олон хуулиуд бас биднийг хүлээгдэж байгаа. Энэ хуулийн хүрээнд ажил амьдралаа шинэчлэх, өөрчлөх, нийгэмлэх, оролцоогоо нэмэгдүүлэх энэ боломжийг хүлээж байгаа маш олон мянган иргэд байгаа. Энэ асуудлыг шийдвэрлэх цаг мөчид та бас сайдаар томилогдож байна гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Өнөөдөр төсөв яригдаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөв маш хүндхэн орж ирж байгаа гэж бид харж байгаа. Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд хөгжил, хүүхдийн эрхийн талаарх энэ асуудалд хүүхэд хамгааллын төсвийн асуудал дээр онцгойлон бас чиглэл өгч байгаа гэдгийг та бас хүлээж аваасай гэж би хүсэж байна. Өөрөөр хэлэх юм бол зөвхөн хүүхэд хамгааллын багц 2.7 тэрбумаар хасагдаж орж ирж байгаа. Би зөвхөн нэгийг л онцолж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглэсэн асуудал төсөв бас хасагдаж орж ирж байгаа. Өнөөдөр хүн амын маань 37.3 хувийг эзэлж байгаа 0-18 хүртэлх насны хүүхдүүдийн асуудал ямар хэмжээнд байгаа билээ? Бид уг нь овоо дөмөгхөн төсөвтэйгөөр хүүхэд хамгааллын чиглэлтэй овоо ажлын дөр

хийж эхэлж байсан боловч яг дахиад төсөв хасагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй болоод хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийнхээ асуудлыг бид тодорхой хэмжээни кэйс менежментээр шийдвэрлэж эхэлж байсан боловч энэ асуудал дахиад орхигдож эхэлж байна. Өнчин хүүхдүүдийн асуудал орхигдож байна, Өнөр бүл өнөөдөр бас төсөвгүй болж байна. Хүүхдүүдийн чиглэлээр хийгдэж байгаа төрийн бус байгууллагуудын хийж байгаа ажлууд дахиад гэгдэх ийм байдал үүсэж байна. Тэгэхээр энэ бүхэн дээр зөвхөн урсгал зардлаар шийдвэрлэх асуудал биш гэдгийг бас онцгойлон хэлэхийг хүсэж байгаа юм.

Та үнэхээр хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хүндхэн байгаа, төсөв нь хүндхэн байгаа энэ цагт сайдаар ажиллаж байгаа хүний хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ онцгойлон анхаараасай гэдэг хүсэлтийг би дахин тавихыг хүсэж байна. Хүүхэд хамгааллын асуудалдаа онцгойлон анхаараарай гэж хүсэх хүсэж байна. Яг төсөв дээр тэд одоо салбарыг хариуцаж байгаа Чинзориг гишүүн, Сарангэрэл гишүүн миний хувьд хүүхэд хамгааллын чиглэл дээр онцгойлон төсвийг нэм гэдэг чиглэлийг өгсөн байгаа. Та шуурхайлан ажиллаарай. Таны ажилд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилогдож байгаа Аюурсайхан гишүүнд юуны өмнө баяр хүргэе. Таныг мэдлэг боловсрол, чадварын хувьд манай улсын хамгийн том салбар болох энэ салбарыг бас сайн авч явна гэдэгт итгэж байна. Ер нь бол энэ салбарыг тэргүүлж байгаа хүн мэдлэг чадвар, туршилагаас гадна хүний амьдралын зовлон жаргалыг мэддэг, хүний амьдралын нарийн ширийнийг ойлгодог, хүний төлөө сэтгэлтэй ийм хүн байх ёстой гэж хардаг. Мөн таныг ийм хүн байгаа гэдэгт бас итгэдэг ээ. Тийм учраас Монгол Улсын хамгийн үнэ

цэнэтэй баялаг болсон бидний хамгийн эрхэм хүмүүс болох хүүхдийн талаар хоёр, гурван зүйл хэлье гэж бодож байна.

Өнөөдөр хүүхдийн хүчирхийлэл өндөр хэмжээнд байна, гэр бүл салалт өндөр байна, цус ойртолт өндөр хэмжээнд байна. Энэ болгонтой ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын ажлын үнэлэмж, тэдний цалин, тэдний нийгмийн асуудал өнөөдөр шийдэгдээгүй байж байгаа. Яг одоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл боловсруулагдаад явж байгаа. Энэ Нийгмийн ажлын хуулийг яаралтай батлуулж, гэр бүл, үр хүүхдүүдийг хамгаалдаг энэ гол ажилтныхаа ажлын үнэлэмжийг дээшлүүлэхэд таныг онцгой анхаарч ажиллана гэдэгт итгэж байна. Түүнээс гадна манай Монгол Улсын 330 суманд мал хариуцсан таван мэргэжилтэн байхад хүүхэд хариуцсан мэргэжилтэн байдаггүй ээ. Тийм учраас энэ орон тоог сайдаар ажиллаж байх хугацаандаа бас батлуулж өгөөч гэж хүсэж байна.

Эцэст нь, Монгол Улсын хүүхэд хөгжил, хамгааллын асуудлыг хариуцсан танай яамны доор агентлаг байгаа. Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын ажлын үр дүн бол өнөөдөр хангалттай биш. Хангалтгүй түвшинд явж байгаа. Энийг би өөрөө хэлж байгаа юм биш, Нэгдсэн Үндэстний Байгууллага үүнийг үнэлсэн. Хоёрдугаарт өнөөдөр энэ нийгэмд байгаа хүүхдийн хүчирхийллийн асуудал тэртээ тэргүй энэ ажилд дүн тавьж байгаа гэсэн үг. Тийм учраас Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, аймаг, нийслэл, энэ орон нутагт байгаа төрийн албан хаагчдын ажлыг дээшлүүлэх, чанаржуулах ажил дээр таныг бас санаа тавьж ажиллаасай гэж хүсэж байна.

Жил болгон 10 тэрбум төгрөг хүүхэд хөгжил, хамгааллын зардалд улсын төсвөөс баталдаг байсан. Үүн дээр нэмээд олон улсын байгууллагуудын хүүхэд хөгжил, хамгааллын төсөв

нийтдээ Монгол Улсад жилдээ 30 тэрбум төгрөг дор хаяж хүүхэд хөгжил, хамгаалалд зарцуулагддаг. Тийм учраас төрийн болон олон улсын байгууллагууд хамтран Монголын хүүхдийн төлөө хүчээ нэгтгэж, сэтгэлээ нэгтгэж, үйл ажиллагаа, зорилгоо нэгтгэж ингэж явахгүй бол Монгол Улсын хамгийн үнэт баялаг болсон хүүхдүүд маань ямар иргэн болж, энэ улсыг ямар иргэд авч явах юм бэ гэдэг асуудал өнөөдөр хамгийн номер нэг санаа зовох хамгийн чухал асуудал болчихсон байгаа шүү гэдгийг бас танд хэлэхийг хүсэж байна. Тэгээд тантай маш ойр энэ хүүхэд хөгжил, хамгааллын асуудал дээр нягт хамтран ажиллана аа. Баярлалаа, амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Алс баруун хязгаарын ард түмэн та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Өглөөнөөс хойш нэмэлт 1 минут байхгүй гэж бүх хүмүүс дээр тийм зарчим тохирсон. Асуудал нэмэхгүй гэж тохирсон. Тэгэхээр адилхан зарчмаар л хандахгүй бол ар өврийн хаалга байж болохгүй, Пүрэвдорж гишүүн ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Үдээс хойш Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа 14 цагт эхэлнэ. 14 цагт гишүүдийг чуулганы танхимд орж ирэхийг хүсье. Одоо 13 цагаас даргын дэргэдэх Зөвлөлийн хуралтай.

Даргын дэргэдэх Зөвлөлийн гишүүд Зөвлөлийн хурал шууд орно. Саранчимэг гишүүн, Гомбилдоогийн Мөнхцэцэг

гишүүн, Пүрэв-Очирын Анужсин гишүүн зохион байгуулж байгаа.

## **ЗАВСАРЛАГА**

Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын намрын чуулганы 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдааны үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаан зарлан мэдээлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол холбогдох болон бусад Байнгын хороог зөвлөлтэй зөвшилцөн тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдээлсэн төслүүдийг танилцуулъя.

1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Чинзориг нарын 4 гишүүн өргөн мэдүүлсэн. Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан байна.

2.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөр мэдүүлсэн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байна гэдгийг мэдээлье.



Хууль, тогтоолын төсөл татан авсан тухай танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Хассуурийн Ганхуяг нарын 5 гишүүн Худалдаа аж үйдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хуралд мэдүүлсэн. Уг хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг 10 дугаар сарын 18-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хуулийн төслийн зарим зүйл, заалтыг дэмжихгүй, уялдуулах шаардлагатай байгаа талаар саналаа илэрхийлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хуулийн төслүүдийг татан авч, дахин шинэчлэн боловсруулж өргөн мэдүүлэхдээ Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулана төслийг дахин боловсруулж өргөн мэдүүлж хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн болно. Худалдаа аж үйдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авч байгааг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж өгөхийг хүсье. Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, Ганхуяг нарын гишүүдээс гэсэн ийм бичиг ирүүлсэн байна. Энэ Худалдаа аж үйдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг татан авч байгаагаа мэдэгдэж байна.

Энэ бол Зөвшөөрлийн хууль, бусад олон хуультайгаа уялдаа холбоотой, нэгдсэн журмаар хэлэлцэх, бас яаралтай хэлэлцэх шаардлагатай хуулиудын тоонд орж байгаа. Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон ийм хуулийн төсөл байна. Худалдаа аж үйдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг татан авч, дахин боловсруулах чиглэлийг өгчихлөө

шүү. Байнгын хорооны дарга аа. Энэ бичгээ аваарай.

**Хоёр.Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлье.**

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Төмөрбаатарын Аюурсайханыг томилсугай.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Одоо Засгийн газрын гишүүн тангараг өргөнө.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан таныг тангараг өргөхийг урьж байна.

**Т.Аюурсайхан:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаас няцвал хуулийн хариуцлага хүлээнэ. /Төрийн дуулал эгшиглэв/

**Г.Занданшатар:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрхэм гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан томилогдож, дөнгөж сая Монгол Улсын Их Хуралд тангараг өргөлөө. Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын даргын дэргэд Зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан сэтгэл зүтгэл, зорилго нэгтэй журмын нөхөр таны боловсрол, мэдлэг, туршлага, хууль засагладаг, нийгэмд шударга ёсыг тогтоох чин эрмэлзэлд тань энэ салбарыг удирдахад чухал нөлөө үзүүлнэ гэдэгт Монгол Улсын Их Хурал бүрэн итгэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэнийхээ хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэх, хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлт, нийгмийн даатгал, халамжийн бодлого, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон гэр бүлийн хөгжлийн асуудал зэрэг хуулиар тогтоосон төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрхэм чухал үүрэг танд ноогдож байна.

Түүнчлэн иргэн бүр нь хөдөлмөр эрхэлдэг, хөдөлмөрийн үр шимээрээ элбэг хангалуун амьдардаг Монголыг цогцлоож, халамжаас хөдөлмөрт шилжих зорилт, нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэл хийх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, эрсдэлт цаг үеийг даван туулах нэн чухал, тулгамдсан асуудал таныг хүлээж байна. Эдгээр асуудалд онцгой анхаарч, цаг алдалгүй ажилдаа шуурхайлан орохыг танаас хүсье. Улсын Их Хурал таны ажлыг дэмжиж, шаардлага тавьж ажиллах болно. Ажилд тань амжилт, амьдралд тань сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа үүгээр өндөрлөснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ